



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



ЦООХОР ИРВЭСНИЙ АМЬДРАХ ОРЧИНД АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ЯВУУЛАХ ЗАРЧИМ, ЗӨВЛӨМЖҮҮД



Улаанбаатар хот
2022 он



БАЙГАЛЬ ОРЧИН
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



ЦООХОР ИРВЭСНИЙ АМЬДРАХ ОРЧИНД АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ЯВУУЛАХ ЗАРЧИМ, ЗӨВЛӨМЖҮҮД

Улаанбаатар хот
2022 он

Зохиогчийн эрх: @ ОУИХС, Ирвэс Хамгаалах Сан

Орчуулсан: Х.Буяндэлгэр, Л.Пүрэвжав

Хянан тохиолдуулсан: А.Баяржаргал, Л.Пүрэвжав

Хувь нэмэр оруулсан: Т.Болдбаатар БОАЖЯ-ны ТХГН – ын удирдлагын газрын мэргэжилтэн

Нүүрний зураг: @ Н.Бат-Эрдэнэ, @ SLCF/SLT, @ Б.Чойдогжамц

Хэвлэлийн эх: И.Бямбаа

Хэвлэлийн компани: Гарьддизайн ХХК

“Та цоохор ирвэсийг олж харсан уу? Үгүй ээ! Энэ гайхалтай биш гэж үү?”

(Маттиессен, 1978)

Зохиогчид: Жастин Шанти Александр, Ранжини Мурали, Т. Болдбаатар, Ажай Бижур, Ли Юхан, Чарудутт Мишра, А. Баяржаргал

Хувь нэмэр оруулсан: Терри Тауншенд, Маттиас Фийчтер, Кустубх Шарма, Жулиан Мэтьюс нар

Дэмжсэн: Даян дэлхийн байгаль орчныг хамгаалах сан (GEF), НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр (UNDP), Олон улсын ирвэс хамгаалах сан (SLT), Байгаль хамгаалах сан (NCF), Барын аялал жуулчлалын оператор компани.

Энэтхэг улсын Байгаль хамгаалах сангийн Ладах, Спити дэх аялал жуулчлалын мэдээллээр хангасан ажилтнууд болон БНХАУ-ын Шан Шуй Байгаль хамгаалах төвийн хамт олонд талархал илэрхийлье. Мөн энэхүү баримт бичгийг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн К.Суряванши, Сури Венкатачалам нарт талархал илэрхийлье.

Энэхүү цоохор ирвэсний амьдрах орчинд аялал жуулчлал явуулах зарчим, зөвлөмжүүдтэй уялдуулан гаргасан Тост, Тосонбумбын БНГ-т аялал жуулчлал явуулах зарчим, зөвлөмжүүдийг хавсаргав.

АГУУЛГА

Товчилсон үг	4
Өмнөх үг	5
Оршил	7
1. Хурдацтай өөрчлөгдөж байгаа цоохор ирвэсний нөхцөл байдал	8
2. Хариуцлагатай аялал жуулчлалд зориулсан заавар, зөвлөмжүүд	10
Зарчим 1. Зэрлэг амьтанд ээлтэй байх	13
1.1 Амьтдын зан авирт саад болохгүй байх (ҮНДСЭН ЗАРЧИМ)	14
1.2 Өгөөш тавихгүй байх (ҮНДСЭН ЗАРЧИМ)	15
1.3 Моторт тээврийн хэрэгслийн нөлөөллийг багасгах (НЭН ЧУХАЛ)	15
1.4 Нөлөөлөл багатай дэд бүтэц, байгууламжийг ашиглах (НЭН ЧУХАЛ)	16
1.5 Хариуцлагатай хог хаягдлын менежментийг бий болгох (ҮНДСЭН ЗАРЧИМ)	18
1.6 Цоохор ирвэсний амьдрах орчинд аялал жуулчлалын зарчмыг бий болгох (МАШ ЧУХАЛ)	18
1.7 Ан агнуурын хоригийг дагаж мөрдөх (ҮНДСЭН ЗАРЧИМ)	19
Зарчим 2. Мэдээлэл, хүндэтгэлийг түгээх	21
2.1 Аялалын цар хүрээг өргөжүүлэх (ЧУХАЛ)	22
2.2 Уламжлалт зан үйлийг хүндэтгэж, бэхжүүлэх (МАШ ЧУХАЛ)	23
2.3 Аялал жуулчлалын зорилгоор амьтдад хүмүүнлэг ёс зүйтэй хандах (МАШ ЧУХАЛ)	23
Зарчим 3. Байгаль хамгаалахад хувь нэмрээ оруулдаг байх	25
3.1 Орон нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах (ЧУХАЛ)	26
3.2 Орон нутгийн байгаль хамгаалах хүчин чармайлтыг дэмжих арга барилыг бий болгох (ЧУХАЛ)	26
3.3 Мониторинг хийхэд хувь нэмэр оруулах (ЧУХАЛ)	27
Зарчим 4. Орон нутгийн түвшинд үр өгөөж хүртэх боломжоор хангах	29
4.1 Орон нутгийн эдийн засгийг дэмжих (МАШ ЧУХАЛ)	30
4.2 Орон нутгийн иргэдийн чадавхжуулах (МАШ ЧУХАЛ)	31
4.3 Орон нутгийн соёлыг хүндэтгэж, мэдлэгийг бий болгох (МАШ ЧУХАЛ)	31
Дүгнэлт	33
Хэрэгцээт эх сурвалжууд	33
Ашигласан бүтээл	34
ТОСТ, ТОСОНБУМБЫН БАЙГАЛИЙН НӨӨЦ ГАЗАРТ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ЯВУУЛАХ ЗАРЧИМ, ЗӨВЛӨМЖҮҮД	35
Тост, Тосонбумбын Байгалийн Нөөц Газарт Аялал жуулчлалын үйл ажиллагааг зохион байгуулах зарчмууд	36
Зарчим 1: зэрлэг амьтад, хүрээлэн буй орчныг хамгаалах зорилгоор зочдын тоог хязгаартай тогтоох	37
Зарчим 2: зэрлэг амьтдад саад болохгүй байх	37
Зарчим 3. Моторт тээврийн хэрэгслийн нөлөөлөлийг багасгах	38
Зарчим 4. Байгалийн нөөц баялгийг хэт их ашиглах, сүйтгэхээс хамгаалах	39
Зарчим 5. Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх	40
Зарчим 7. Эдийн засгийн үр ашгийг орон нутгийн түвшинд бий болгох	41
Зарчим 8. Орон нутгийн соёлыг хүндэтгэж, мэдлэг ойлголт бий болгох	42
Зарчим 9. Орон нутаг дахь зэрлэг амьтдыг судлах болон хамгаалах асуудлыг дэмжих	43
Дүгнэлт	44
Ашигласан бүтээл	44

Товчилсон үг

БОАЖЯ – Байгаль орчин аялал жуулчлалын яам

ДЦИЭХХ – Дэлхийн цоохор ирвэс түүний экосистемийг хамгаалах хөтөлбөр

ИХС – Ирвэс Хамгаалах Сан

ОУИХС – Олон Улсын Ирвэс Хамгаалах Сан

ТХГН – Тусгай хамгаалалттай газар нутаг



ӨМНӨХ ҮГ

Монголчуудын уламжлалт ахуй, амьдралын хэв маяг нь биологийн олон янз байдал, түүний дотор нэн ховор, ховор амьтдын өсөлт хөгжилтөнд сөрөг нөлөө учруулахгүйгээр олон зуунд өвлөгдөн ирсэн. Гэвч сүүлийн жилүүдэд эрчимжсэн байгалийн баялгийн ашиглалт, аж ахуйн олон талт үйл ажиллагаа хийгээд уур амьсгалын өөрчлөлт, мал сүргийн тооноос үүдэлтэй бэлчээрийн хомсдол нь зэрлэг амьтдын тоо толгой, тогтвортой өсөлтөд сөргөөр нөлөөлөх болов.

Үүнтэй холбоотойгоор Дэлхийн цоохор ирвэс, түүний экосистемийг хамгаалах хөтөлбөрөөс олон орны туршлага, эрдэмтдийн судалгаанд тулгуурлан "Цоохор ирвэстэй таарах үед авах арга хэмжээ, болзошгүй эрсдэл,

зөрчлөөс сэргийлэх бодлогын зөвлөмж" боловсруулсныг монгол орны нөхцөлд тохируулан шинэчилжээ. Тухайлбал, манай улсад аяллын шинэ төрөл болон хөгжиж буй цоохор ирвэс харах аяллын зарчмыг Тост, Тосонбумбын нурууны УТХГ-аар жишээ болгон оруулсан нь талархууштай.

Энэхүү зөвлөмж ховордсон зүйлийг хамгаалахад, уламжлалт аж ахуй, аялал жуулчлалыг хариуцлагатайгаар явуулах хэн бүхэнд тустай гарын авлага болсон гэдэгт эргэлзэхгүй байна.

Байгаль хамгааллын зохистой менежментийг нэвтрүүлэх аливаа санаачилгад түүчээлэн оролцдог Ирвэс хамгаалах сангийн хамт олонд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Эрхэмбаярын БАТТУЛГА

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга



Аялал жуулчлалыг зохистой хөгжүүлэх нь улс орны эдийн засаг орон нутгийн хөгжилд чухал ач холбогдолтой. Эко туризм, зэрлэг амьтанд суурилсан аялал жуулчлал гэх мэт байгалийн үзэсгэлэнд тулгуурласан аялал жуулчлалын чиг хандлага дэлхий нийтэд хүч түрэн хөгжиж байна. Монгол оронд ч энэ чиглэлийн аялал хөгжих нь тодорхой.

Цоохор ирвэс бол газрын доорх баялагаас ялгаагүй монгол орны байгалийн нандив өв. Энэ амьтны экологийн тэнцвэрт байдалд үзүүлэх ач холбогдол өндөр. Нуугдмал амьдралтай түүнийг харах гэсэн жуулчдын сонирхол их, ийм чиглэлийн аялалууд ч манай оронд явагдаж эхлээд удаагүй байна. Аялал жуулчлалыг зөв

зохистой явуулах нь энэхүү амьтны оршин тогтноход чухал нөлөөтэй. Тиймээс ч цоохор ирвэсний амьдрах орчинд аялал жуулчлалыг явуулахдаа анхаарч баримтлах зарчим, зөвлөмж бүхий баримт бичгийг гаргах цаг үе өнөөдөр мөн гэдэгт итгэлтэй байна.

Ирвэс Хамгаалах Сан энэхүү зарчим, зөвлөмжинд тус салбарын мэргэжилтнүүдийн санаа бодлыг тусгаж монгол орны хөрсөнд буулган хэвлүүлж байгаадаа баяртай байна.

Тур операторууд, хөтөч, орон нутгийн удирдлага, иргэд, аялагч жуулчдын цаашдын үйл ажиллагаанд хувь нэмэр болно хэмээн найдаж байна.

Ирвэс Хамгаалах Сангийн
гүйцэтгэх захирал

 А.Баяржаргал

1. ОРШИЛ

Энэхүү зарчим, зөвлөмж нь цоохор ирвэсний амьдрах орчинд нийгэм экологийн хариуцлагатай аялал жуулчлалыг явуулахад анхаарах удирдамж юм. Голчлон аялал жуулчлалын салбарынханд зориулагдсан боловч байгаль хамгааллын болон эдийн засгийн хөгжлийн бодлого боловсруулагч нарт хэрэгтэй байж болох юм. Энэ нь бидний одоогийн мэдлэг дээр тулгуурласан тул цаашид сайжруулж, шинэчлэх боломжтой. Цаашдаа шинэлэг санал, зөвлөмж, хэрэгжиж буй сайн туршлагуудаар энэхүү баримт бичгийг баяжуулагдана.

Өндөр уулын бүс өнөөгийн жуулчдад илүү ойрхон болсноор цоохор ирвэсний амьдрах орчинд аялал жуулчлал хөгжсөөр байна. Цоохор ирвэсний амьдрах орчин нь эрс тэс уур амьсгал бүхий ихэвчлэн өндөр уулын бүс бөгөөд Төв болон Өмнөд Азийн

12 улсууд (Афганистан, Бутан, Хятад, Энэтхэг, Казахстан, Киргиз, Монгол, Непал, Пакистан, Орос, Тажикистан, Узбекистан) хамрагддаг. Дэлхийн цоохор ирвэсний тоо толгой тодорхойгүй хэвээр байгаа боловч ойролцоогоор 3,920-6,390 бодгаль бий гэж үздэг. Цоохор ирвэсний амьдрах орчин нь эрс тэс орчинд удаан хугацаагаар оршин тогтнож ирсэн олон янзын соёл уламжлалын өлгий нутаг байдаг.

Байгалийн унаган төрх, өвөрмөц соёл, биологийн олон янз байдал гээд жуулчдад их зүйлсийг энэхүү амьдрах орчин санал болгоно. Зам, тээвэр, дэд бүтэц сайжирч, орлого нэмэгдэхийн хэрээр эдгээр чиглэлд хийх олон улсын төдийгүй дотоодын аялал жуулчлал улам бүр өссөөр байна.



Зураг 1: Цоохор ирвэсний дэлхийн тархац (IUCN; URL: www.iucnredlist.org)

Цоохор ирвэсний амьдрах орчинд аялал жуулчлалыг үр дүнтэй удирдан зохион байгуулж чадвал жуулчид дахин давтагдашгүй дурсамжийг авангаа орон нутгийн амьжиргааг дээшлүүлэх, ирвэс

болон биологийн олон янз байдлыг хамгаалах үйлсэд дэмжлэг үзүүлэх боломжтой. Тиймээс өндөр уулсын экосистемийн өвөрмөц байдлыг ашиглан байгаль хамгаалах үйлсэд хувь нэмрээ

оруулах, олон нийтийн дэмжлэгийг үүнд чиглүүлэх боломжтой юм.

Гэвч хяналт, хариуцлагагүй аялал жуулчлал нь эмзэг экосистем болон энд орших ургамал, амьтдад аюул учруулж болзошгүй байдаг. Хариуцлагатай, ул мөргүй, экосистемийн эмзэг болон нутгийн иргэдийн соёлын ялгаатай байдалд мэдрэмжтэй хандан үйл ажиллагаа явуулснаар тухайн газар нутгийг унаган төрхөөр нь үлдээх, урт хугацааны туршид аялал жуулчлал явуулах боломжийг бий болгоно. Үүнийг орон нутгийн онцлогт тохирсон удирдамж, журам, зохицуулалтын тогтолцоогоор шийдэж болно.

Энэхүү баримт бичигт цоохор ирвэсний амьдрах орчинд хариуцлагатай аялал жуулчлалыг төлөвлөх, хөгжүүлэх, хэрэгжүүлэх, хяналт тавихад шаардагдах **ЗАРЧИМ, ЗӨВЛӨМЖ** - ийг тусгасан болно. Эдгээр зарчмуудыг хариуцлагатай аялал жуулчлал гэж байгаль орчинд аялахдаа нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлж, байгаль хамгаалалд хувь нэмэр оруулахыг хэлнэ хэмээн тодорхойлогдох экотуризмын салбараас санаа авч боловсрууллаа (Олон улсын экотуризмын нийгэмлэг, 1990).

1. ХУРДАЦТАЙ ӨӨРЧЛӨГДӨЖ БАЙГАА ЦООХОР ИРВЭСНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Аялал жуулчлал хурдацтай өргөжиж байгаа ч түүний нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөө ялангуяа цоохор ирвэсний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа тухай мэдээлэл хомс байна. Нөлөөллийг ойлгохын тулд эхлээд цоохор ирвэсний өнөөгийн байдлыг тодорхойлж, зэрлэг амьтан, нутгийн иргэдийн хоорондын харилцааг харгалзан үзэх нь аялал жуулчлалын практикт чухал ач холбогдолтой юм.

Цоохор ирвэс нь өнөөг хүртэл Төв болон Өмнөд Азийн уулсын янз бүрийн өндөрлөгт амьдарч ирсэн нь зөвхөн эдгээр нутгийн иргэдэд л ойр дөхөм байсан. Гималайд далайн түвшнээс дээш 3000-

Олон улсын экотуризмын нийгэмлэг нь (TIES) байгаль хамгааллыг бэхжүүлэх, орон нутгийн иргэдийн оролцоонд тулгуурлах, байгаль, нутгийн ард иргэдэд эдийн засгийн үр өгөөжтэй байх, жуулчдад тааламжтай байх гэсэн дөрвөн зүйлд ач холбогдол өгдөг. Бид үүнийг цоохор ирвэсний амьдрах орчинд аялал жуулчлал дэмжихэд зориулж хялбаршуулж ашигласан болно. Байгаль хамгаалалд орон нутгийн иргэдийн оролцоо, санаачилгыг дэмжих, тогтвортой байдлыг хангахад онцгойлон анхаарсан билээ.

Дөрвөн үндсэн зарчим нь:

- Байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх
- Мэдээлэл, хүндлэлийг сурталчлах
- Байгаль хамгаалахын ашиг тусыг ойлгох
- Орон нутгийн түвшинд иргэдэд үр өгөөжтэй байх гэсэн тулгуур асуудлуудаас бүтнэ.

Эдгээр зарчмын дагуу аялал жуулчлалын болон холбогдох төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд дараах зөвлөмжүүдийг өгч байна.

5400 метрийн өндөрт оршин тогтнодог бол Монгол, ОХУ-д 1000-2000 метрийн өндөрт ч нутагладаг байна.

Цоохор ирвэсний ландшафт нь ихэвчлэн цөлөрхөг хээр, хээр бүхий хуурай өндөр уулын системээс бүрддэг. Өвлийн саруудад ирвэсний амьдрах орчны ихэнх хэсэг нь цасан бүрхүүлийн улмаас очих боломжгүй болдог ч зуны цагт боломжтой. Түвдийн өндөрлөгт нийт гадаргууны 30 гаруй хувь нь 11-р сараас 4-р сар хүртэл цасан бүрхүүлтэй байдаг (Pu нар, 2007). Ийм өндөрлөг газруудад уур амьсгалын өөрчлөлт нөлөөлж жилийн дундаж температур болон хур тунадасны хэмжээ ихэсч, ой мод өндөр уул нурууд руу

түрэх магадлалтай (IPCC, 2007; Форрест ба бусад, 2012). Судалгаанаас үзэхэд уур амьсгалын өөрчлөлтэй холбоотойгоор цоохор ирвэсний амьдрах орчин ялангуяа Гималайн нуруунд тодорхой хэмжээгээр багасаж болзошгүй юм (Forrest et al., 2012).

Эндхийн биологийн олон янз байдал харьцангуй өвөрмөц. Эрс тэс, хуурай, цаг уурын хувьсамтгай нөхцөлд дасан зохицсон ургамал, амьтны аймаг нь цоохор ирвэсний тоо толгойд нөлөөлдөг. Ялангуяа янгир ямаа, хөх хонь зэрэг туруутан амьтдын төрөл зүйл нь цоохор ирвэсний идэш тэжээлийн анхдагч эх үүсвэр болдог (Lyngdoh et al., 2014). Аргаль ба огдой зэрэг амьтад ч цоохор ирвэсний идэш тэжээлийн нэгэн хэсэг болдог байна. Цоохор ирвэс нь чоно, шилүүс, мануул зэрэг бусад махчин амьтадтай зэрэгцэн амьдардаг ч тэдгээрийн харилцаа холбооны талаар судлагдсан зүйл ховор байна (Alexander et al., 2015). Ургамлын цуглуулгад олон төрлийн сонирхолтой өвс, цэцэгт ургамал, үр, бут сөөг энэ бүс нутагт байдаг нь цоохор ирвэсний идэш тэжээл бологч амьтад хамгийн чухал хоол хүнсний эх үүсвэр болдог.

Эдгээр амьдрах орчин нь хүний үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын төслүүдэд өртөж буй эмзэг экосистемийн төлөөлөл юм (Snow Leopard Network, 2014). Цоохор ирвэсний гол аюул занал нь хууль бус ан, мал идсэний төлөө өширхөн хороох, идэш тэжээлийн хомсдол зэргээс гадна бүтээн байгуулалт, хотжилт, уул уурхай зэрэг нь тэдний амьдрах орчныг доройтуулан, хуваагдал үүсгэж байна. Эдгээр аюул занал нь орон орноосоо шалтгаалан он цагийн явцад харилцан адилгүй байдаг (Snow Leopard Network, 2014).

Орон нутгийн иргэд нь уламжлалт мал аж ахуй, газар тариаланд тулгуурлан амьжиргаагаа залгуулдаг ба экосистемийн үйлчилгээнээс тэдний амьжиргаа ихээхэн хамааралтай (Handa 1994, Murali et al., 2017). Хөдөө аж ахуй, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн нь орон нутгийн эдийн засгийн ихэнх хэсгийг бүрдүүлдэг. Цоохор ирвэстэй нутагт ажил эрхлэх

боломж муу. Иргэд мал аж ахуй эрхлэхээс гадна, ховор ургамал түүж борлуулах (ж.нь катерпиллар мөөг) гэх мэт өдрийн ажил, хувийн хэвшлийн жижиг бизнес эрхлэх, орон тооны ажлын байр хомс учраас заримдаа уул уурхай, аялал жуулчлал зэрэг салбарт ажил эрхэлдэг байна.

Ихэнх ирвэстэй нутгийн иргэд, ан амьтадтай орон зайг хуваан амьдардаг. Тиймээс ч цоохор ирвэс нь мал аж ахуйд шууд аюул занал учруулахаас гадна энэхүү бэлчээрийн эдийн засгийн салшгүй нэг хэсэг болдог. Зарим иргэд ирвэс мал барих явдал их байгаад эмзэглэж, цоохор ирвэст сөргөөр ханддаг (ж.нь Аннапурна тусгай хамгаалалттай газар, Непал (Aryal et al., 2014)) бол нөгөө нэг хэсэг нь үүнд илүү тэвчээртэй зохицон орших жишээтэй (Li et al., 2013a). Цоохор ирвэс хамгаалал нь өнөөг хүртэл ирвэс ба хүний харилцаан дахь уян хатан хүлээцтэй байдлыг уриалж зэрлэг амьтантай зохицон амьдрах арга замыг эрэлхийлж иржээ. Олон Улсын Ирвэс Хамгаалах Сан (ОУИХС – Snow Leopard Trust (SLT) болон түүний түнш байгууллагууд гар урлал (Ирвэс Энтерпрайз хөтөлбөр), малын даатгал, малын вакцинцинжуулалт, махчин амьтнаас мал хамгаалах хашаа хороо, хууль бус антай тэмцэх сургалт, байгаль хамгаалах боловсрол олгох зэрэг олон нийтийг хамарсан байгаль хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Гол нь эдгээр ажлуудыг нутгийн иргэдтэй нягт уялдаатайгаар зохион байгуулж хэрэгжүүлдэг юм. Эдгээр хүчин чармайлтууд нь олон улсын хэмжээний бодлогын түвшинд (жишээ нь Дэлхийн Цоохор Ирвэс түүний Экосистемийг Хамгаалах Хөтөлбөр (ДЦИЭХХ - Global Snow Leopard Ecosystem Protection (GSLEP гэх мэт) дэмжигдэж иржээ.

Орчин үед экологийн ийм эмзэг газруудад гадна, дотны жуулчид ирэх нь улам бүр нэмэгдсээр байна. Эдний дунд дээд зэрэглэлийн тав тух, сайн хөтөч үйлчилгээтэй аялах сонирхолтой нэг хэсэг байхад адал явдал хайгч үүргэвчтэй явган аялагчид хүртэл бий. Аялал жуулчлалын дэд бүтэц, жуулчдын эрэлт хэрэгцээ, маршрут гэх мэт нь улс

орнуудын хувьд өөр өөр байх ч нөхцөл байдал хурдацтай өөрчлөгдөж байна. Ялангуяа энэхүү алслагдмал амьдрах орчинд хүрэх зам тээвэр дэд бүтэц хөгжиж буйтай холбоотойгоор жуулчдын тоо эрс нэмэгдэж байна.

Аялал жуулчлал нь хүрээлэн буй орчин, нийгэмд өргөн цар хүрээтэйгээр нөлөөлж болно (Хүснэгт 1). Тухайн бүс нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ аливаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлж эерэг хандлагыг нутагшуулах нь зүйтэй юм. Өөрчлөлт зайлшгүй байх

ёстой ч нутгийн иргэд энэхүү өөрчлөлтөнд дасан зохицох, хяналт тавих боломжтой байх нь чухал юм. Сөрөг нөлөөллийг бууруулахын тулд нутгийн иргэд аялал жуулчлалын үйл ажиллагаанд идэвхитэй оролцох, энэ салбарт хувь нэмрээ оруулах, ашиг хүртэгч байх нь чухал юм (Kumar and Kumar 2014). Жишээ нь Төв Энэтхэгийн эко аялал жуулчлалын талаар хийсэн судалгааг дэлгэрүүлж харвал илүү ойлгомжтой болно (Chundawat et al. 2017).

Хүснэгт 1. Байгаль орчин, нийгэмд сөргөөр нөлөөлж болзошгүй аялал жуулчлалын үйл ажиллагаанууд

Байгаль орчин, нийгэмд сөргөөр нөлөөлж буй аялал жуулчлалын үйл ажиллагаанууд

Байгаль орчинд	Нийгэмд
<p>Амьдрах орчныг сүйтгэж буй дэд бүтцийн хөгжил</p> <ul style="list-style-type: none">• Аялал жуулчлалын зориулалт бүхий нүсэр барилга байгууламжууд• Ус ашиглалт• Тээврийн хэрэгсэлүүд (зам, төмөр зам, шороон зам, агаарын тээвэр)• Хог хаягдал (бохирдол)	<p>Орон нутгийн ард иргэд, соёл зан үйлд аялал жуулчлалаас үзүүлж буй сөрөг нөлөөллүүд</p> <ul style="list-style-type: none">• Орон нутагт жуулчдын оруулж буй хөрөнгө нутгийн иргэдийн сонирхол, зан үйлд сөргөөр нөлөөлөх, өрсөлдөөн үүсгэх• Жуулчдын зүй бус хувцаслалт• Соёлын үнэт зүйлс, зан заншлыг жуулчдын сонирхолд нийцүүлэн арилжаалах
<p>Зэрлэг амьтдад сөргөөр нөлөөлдөг жуулчид ба тур операторуудын үйл ажиллагаа</p> <ul style="list-style-type: none">• Жуулчид, гэрэл болон кино зурагчдын зэрлэг амьтдыг үргээн зайлуулж буй хариуцлагагүй зан үйл• Өгөөш тавих	

2. ХАРИУЦЛАГАТАЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛД ЗОРИУЛСАН ЗААВАР, ЗӨВЛӨМЖҮҮД

Аялал жуулчлал нь цоохор ирвэсэнд аюул дарамт үүсгэхээс зайлсхийж, байгаль орчинд ээлтэй байлгахын тулд тус салбарын нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах сайн туршлагауудыг дагаж мөрдөх, ёс зүйн хэм хэмжээг танилцуулж сурталчлах нь чухал юм. Нөхцөл байдал бүр өөрийн онцлогтой тул ерөнхий нэгдсэн зааварчилгаа

өгөх боломжгүй ч хариуцлагатай аялал жуулчлалын дөрвөн үндсэн зарчмыг тодорхойлж, тэдгээрийг нөхцөл байдалд тохируулан дагаж мөрдөх боломжтой (Зураг 2). Эдгээр зарчмуудыг цоохор ирвэс хамгаалах зөвлөмжүүдтэй хамт доор үзүүлэв. Мөн байгаль орчин, орон нутагт нөлөөлөх байдалд нь тулгуурлан **Үндсэн, Нэн чухал, Чухал** гэж ангилав.

ХАРИУЦЛАГАТАЙ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЗАРЧМУУД

Зураг 2: Хариуцлагатай аялал жуулчлалын үндсэн дөрвөн зарчим (TIES 1990)

1

Зэрлэг амьтанд ээлтэй байх

- Амьтны зан авирт саад болохгүй байх
- Өгөөш тавихгүй байх
- Нөлөөлөл багатай дэд бүтэц, байгууламжийг ашиглах
- Мэргэжлийн байгууллагын зааврыг дагах

2

Мэдээлэл, хүндэтгэлийг түгээх

- Ирвэс төвтэй аялалаас аль болох зайлсхийх, бусад бүтээгдэхүүнийг өргөжүүлэх
- Уламжлалт, эерэг зан үйлийг сэргээн бэхжүүлэх
- Сургалтын материалаар хангах

3

Байгаль хамгаалалд хувь нэмэр оруулах

- Орон нутгийн байгууллагуудтай холбоотой ажиллах
- Орон нутгийн байгаль хамгаалах хүчин чармайлтыг дэмжих
- Нөлөөллийг хянахад хувь нэмэр оруулах

4

Орон нутгийн түвшинд үр өгөөж хүргэх боломжоор хангах

- Иргэдэд эдийн засгийн боломж олгох
- Нутгийн иргэдийн чадавхийг дээшлүүлэх



@ SLCF/SLT



@ SLCF/SLT



ЗАРЧИМ I

ЗЭРЛЭГ АМЬТАНД ЭЭЛТЭЙ БАЙХ

Жуулчдыг цоохор ирвэсний амьдрах орчинд аялуулахдаа бие, соёлын зэрэг нөлөө үзүүлэхэд бэлдэж, ингэснээр цоохор ирвэс цааш оршин тогтнох болно.

ЗӨВЛӨМЖҮҮД:

1.1 АМЬТДЫН ЗАН АВИРТ СААД БОЛОХГҮЙ БАЙХ (ҮНДСЭН ЗАРЧИМ)

Жуулчдын нягтрал болон тэдний зэрлэг амьтадтай харьцах хэв маягийг зохицуулах нь маш чухал юм. Ирвэсний амьдрах орчинд гэнэт олон тооны жуулчид орж ирвэл ирвэс болон түүний идэш тэжээл бологчид, мөн тухайн орчны ургамалд сөрөг нөлөө учруулж болзошгүй. Хог хаягдалын хэмжээ, хүрээлэн буй орчинд үзүүлж буй дарамт нь тухайн амьдрах орчныг гамшгийн зэрэгт хүргээд зогсохгүй аялал жуулчлалын салбарыг доройтуулж болзошгүй. Зочлох газрын шинж чанар, түүний эмзэг байдал зэргээс шалтгаалан орон нутгийн түвшинд жилд авах жуулчдын квотыг тогтоож өгөх нь зайлшгүй хэрэгтэй юм.

Жишээ: Хятадын Ангсай дахь цоохор ирвэсний амьдрах орчинд зочлох жуулчдын тоог 1516 км² талбайд 3-4 хүнээс бүрдэх 3 бүлгээр хязгаарлаж өгсөн байдаг.

Тусгай хамгаалалттай газар, цоохор ирвэсний амьдрах орчинд ирэх жуулчдын тоо, жуулчны бааз, тээврийн хэрэгслийн тоог маш сайн хянаж, тухайн амьтны амьдрах орчны доройтол, хуваагдлыг багасгахын тулд тогтмол үнэлгээ хийх шаардлагатай. Жил бүр орон нутгийн засаг захиргаа, тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаанаас жуулчны тээврийн хэрэгсэл/машин, ор хоногийн тоонд хязгаарлалт тогтоон зохих журмын дагуу мөрдүүлэхийг зөвлөж байна.

Ирвэсний амьдрах орчинд зочлох жуулчдын тоог зохицуулах зорилгоор соёл, зан үйлийн болон хөдөө аж ахуйн аялалуудыг зохиож болно. Жуулчдын тоон квот болон менежментийн бусад чухал асуудлуудыг нутгийн иргэдтэй зөвлөлдсөний үндсэн дээр гаргах нь зүйтэй. Орон нутгийн засаг захиргаа, ТББ, нутгийн иргэдтэй хамтран хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийх, аялал жуулчлалын бүсүүдийг тогтоох, ялангуяа аялал жуулчлалд хязгаарлалттай ашиглах бүс эсвэл огт аялал жуулчлалгүй бүс гэх мэтчилэн

тогтоож өгөх нь чухал.

Үйлчлүүлэгчид яагаад ийм хязгаарлалт хэрэгтэй байгаа болон аялал жуулчлалын сөрөг нөлөөллийн талаар сайн мэдлэгтэй тул тур операторууд энэхүү зарчмыг дэмжин ажиллах хэрэгтэй. Тур операторууд тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагууд, орон нутгийн иргэдтэй нягт хамтран ажиллах хэрэгтэй (жишээ нь тасалбарын механизм, баазын талбайн хязгаарлалт, захиалга, зогсоолын журам гэх мэт). Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутаг нь аялал жуулчлалын маршрутыг тодорхойлох, ан амьтдын амьдрах чухал орчныг таних тэмдэг, тэмдэглэгээг Амьтны тухай хууль, ТХГН – ын тухай хууль түүний холбогдох хууль тогтоомжуудаар хангаж ажилладаг.

Цоохор ирвэсний амьдрах орчинд зэрлэг амьтдад ойртож, гэрэл зураг авах нь ихсэж байна. Үүнийг сайтар бодож, төлөвлөж хийх нь эдгээр зүйлүүдэд хор хөнөөл бага учруулах болно. Харамсалтай нь жуулчдад зэрлэг амьтан харуулах, ойртох очих оролдлого хийх дрон мэт шинэ технологи ашиглах, өгөөш тавих зэрэг үйлдлүүд нь амьтдад шинэ эрсдэлүүдийг үүсгэж байна. Жуулчдыг (мэргэжилтнүүдийн мэдээлэл эсвэл товхимолоор дамжуулан) ажиглаж буй амьтдын зан авир, хэрхэн тэдэнд саад, хор хөнөөл учруулахгүй байх талаар зайлшгүй мэдээлэл өгч удирдан аялуулах нь зүйтэй.

Цоохор ирвэс нь ганцаараа нуугдмал амьдардаг амьтан тул цөөн хүний дэргэд ч амархан стресст ордог. Хэрэв жуулчдыг ирвэс ажиглуулахаар авчрах бол амьтдыг стресст оруулахгүй, тэдний тайван байдлыг хангахын тулд холын зай барих нь хэрэгтэй. Хэрэв амьтан стресст орсон мэт санагдвал түргэн холдох нь зайлшгүй чухал юм.

Гэрэл зураг, дүрс бичлэг хийхийн тулд амьтныг зориудаар үймүүлэх, хөөх, чанга

дуу чимээ гаргах, амьтдын хөдөлгөөнд саад учруулах зэрэг түрэмгий тактикийг хатуу хориглож, арга хэмжээ авах ёстой. Зураг авалтын иймэрхүү үйлдлээс болж зугтаж явсан цоохор ирвэс хаднаас унаж байсан тохиолдол бүртгэгдсэн байна.

Тиймээс дараах зөвлөмжийг дагаж мөрдөхийг зөвлөж байна. Үүнд:

- Зэрлэг амьтад ойртоход амархан үргэдэг нөгөө талаар зэрлэг амьтаас аль болох зайтай байх нь эрсдэлээс зайлсхийх арга болно. Цоохор ирвэс болон бусад зэрлэг амьтаас дор хаяж 300 -1000 метрийн зайд ажиглаж харин хэрхэвч дагаж болохгүй.
- Гүемээ дагуулсан эм цоохор ирвэс амархан хямарч, үүрээ орхих түүнчлэн гүемд эрсдэл ихтэй байдаг тул үүрэнд ойртох, гүемийн зураг авахыг хориглоно.
- Зэрлэг амьтад уст цэгийг олон хоног ашиглах тохиолдол байдаг тул түүнд 300 - 1000 метрээс багагүй зайд ойртохыг хориглоно.
- Махчин шувуудын үүрэнд ойртохгүй байх.

- Зэрлэг амьтдыг машинаар болон явганаар хөөж, дагахыг хориглоно. Амьтны зүг хувцас хунар шидэх, даллах, тээврийн хэрэгслээр явж буй амьтны замд саад учруулах, амьтныг барих, хорих зэргээр хөдөлгөөнийг хязгаарлах, зогсоох, саад учруулах арга хэрэглэж болохгүй
- Шөнийн хөгжим алсад байгаа зэрлэг амьтад ихээхэн саад болдог тул жуулчны баазууд дуу чимээний түвшинг хязгаарлана.
- Дрон гэх мэт ажиглалтын шинэ технологийн цоохор ирвэсэнд үзүүлэх нөлөө нь тодорхойгүй байна. Бусад том хөхтөн амьтад дээр хийсэн цөөн тооны судалгаагаар ойрын зайд дрон ашиглаж байгаа нь тухайн амьтныг стресст оруулдаг болохыг нотолсон. Дроныг зөвхөн зэрлэг амьтдын мэдлэгтэй менежерүүд эсвэл эрдэмтдийн удирдлаган дор ашиглах ёстой. ТХГН болон бусад уулархаг бүс нутагт дроны хэрэглээг хянаж, зохицуулах шаардлагатай.

1.2 ӨГӨӨШ ТАВИХГҮЙ БАЙХ (ҮНДСЭН ЗАРЧИМ)

Цоохор ирвэсэнд ойртож, харуулахын тулд ямар ч тохиолдолд **ӨГӨӨШ** тавихыг хориглоно. Ингэснээр зэрлэг амьтныг асар их эрсдэлд оруулахаас гадна мал барих асуудал ихсэх, тэдний зан авирт тааламжгүй өөрчлөлт орох, ирвэс хоорондоо өгөөшны төлөө зодолдох, хүмүүст дасах зэрэг ноцтой үр дагавартай.

Зэрлэг амьтны анхаарал татахын тулд үхсэн болон амьд идэш болох амьтныг уяж болохгүй. Ямар ч махчин амьтад хөдөлгөөн мэдэрч ангуучилдаг. Амьтныг тэжээх, өгөөшлөх нь амьтдын төрөлхийн зан төрхийг өөрчилж, зулзагануудаа энэ зангаараа сургахад хүргэдэг (энэ

нь махчин амьтдын дотор зан төрхийн асуудал үүсгэнэ гэсэн үг).

Мал барих асуудал ихэссэнээр ирвэсэнд хандах нутгийн иргэдийн хандлага таагүй болж мал барьсны төлөө өширхөн хороох явдал газар авах магадлалтай. Энэ нь орон нутгийн байгаль хамгаалах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлнө. Үүнтэй ижил шалтгаанаар бусад амьтад ч гэсэн өгөөш хаяхыг хориглоно. Үүнд туруутан амьтад хужир мараа тавих (цаг агаарын тааламжгүй үеэс бусад үед), шувуу болон зэрлэг амьтныг дуурайн дуугарч хариу үйлдлээр нь байршил зэргийг тогтоох гэх мэт багтана.

1.3 МОТОРТ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН НӨЛӨӨЛЛИЙГ БАГАСГАХ (НЭН ЧУХАЛ)

Жуулчид тусгай хамгаалалттай газар нутаг, цоохор ирвэсний амьдрах орчин, уулархаг нутгаар моторт тээврийн

хэрэгслээр (автомашин, мотоцикл) аялахыг зөвшөөрнө. Гэвч ийм тээврийн хэрэгслийн нөлөөлөл зэрлэг амьтад

тэдгээрийн амьдрах орчны эрсдэлийг нэмэгдүүлдэг хамгийн том эх үүсвэр учир үүнийг аль болох багасгах шаардлагатай. Аялал жуулчлалын тур операторууд ТХГН машинаар зорчих стандарт дүрмийг дагаж мөрдөх үүрэгтэй.

Монгол орны цоохор ирвэсний амьдрах орчны ихэнх нь засмал замгүй ч тусгай хамгаалалттай газар нутаг эсвэл өндөр уулын ландшафт доторх жуулчдын сонирхлыг татдаг гол газруудад нэвтрэх боломжийг олгодог шороон замын сүлжээ байдаг. Эдгээр замын нөхцөл нь улирлын шинж чанартай байх тул аялал хийхээс өмнө сайтар шалгаж үзэх шаардлагатай. Бүх тээврийн хэрэгсэл нь орон нутгийн засаг захиргаа, тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагуудын тодорхойлсон замын сүлжээгээр явах ёстой. Энэхүү замын сүлжээ аялал жуулчлалын гол газруудаар дайрах боломжтой ч амьтдын эмзэг амьдрах орчин, хөндий, устцэгүүдээс зайлсхийх зорилгоор хийгдсэн байна. Энэ нь Монгол Улсын хууль тогтоомжийн нэг хэсэг учраас тусгай хамгаалалттай газар нутагт аялахдаа хүндэтгэлтэй хандаж, дагаж мөрдөх шаардлагатай.

1.4 НӨЛӨӨЛӨЛ БАГАТАЙ ДЭД БҮТЭЦ, БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАХ (НЭН ЧУХАЛ)

Цоохор ирвэс түүний идэш тэжээл бологч амьтдын өлгий нутаг өндөр уулын экосистем нь маш эмзэг бөгөөд амархан доройтолд ордог. Тиймээс аялал жуулчлалын дэд бүтэц, байгууламжууд тухайн газрын байгалийн нөөцөд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг сайтар бодож үзэх нь чухал юм.

Аялал жуулчлал нь эдгээр байгалийн нөөцийн хямралын эх үүсвэр болж, заримдаа бохирдолд хүргэдэг.

Нөлөөлөл багатай дэд бүтэц гэдэгт жуулчны бааз ба түүнийг дагалдсан цахилгаан, хоол хүнс, ус, хог хаягдалыг зохицуулах үйлчилгээнүүд багтана. Эдгээр нь байгалийн нөөцийг хамгийн бага ашигладаг, байгальд амархан уусах материалын хэрэглээ бүхий тогтвортой ашиглалтыг хэлнэ (Crawford 2000). Тухайн газрын цаг уур, газарзүйн болон соёлын онцлогоос шалтгаалж

Тухайн заасан замаас гарч шинэ зам гарган машин жолоодохыг хориглоно. Зэрлэг амьтанд ойртохын тулд замаас гарах нь тухайн амьтад болон цоохор ирвэсний амьдрах орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй тул шинээр шороон зам гаргах эсвэл гаргасан замын чиглэлийг өөрчилж болохгүй.

Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагууд, орон нутгийн засаг захиргаа, ард иргэд дуу чимээ ихтэй тээврийн хэрэгсэл ашиглахыг хориглох эсэхээ шийдэх хэрэгтэй.

Харанхуйд автомашины гэрэл эсвэл хүчтэй гар чийдэнгээр дамжуулан амьтдыг гэрэлтүүлэхийг хориглоно. Энэ нь зэрлэг амьтад тэдгээрийн зан төрх ялангуяа үржлийн үеийн зан төрхөд нөлөөлөх эрсдэлтэй.

Тусгай хамгаалалттай газар нутаг эсвэл орон нутгийн хамгаалалттай газруудын хилийн доторх жуулчны тээврийн хэрэгслийн тоог тухайн хамгаалалтын захиргаа, орон нутгийн захиргаанаас зохицуулах шаардлагатай.

дэд бүтэц дахин давтагдашгүй онцлог шинжтэй байдаг. Нөлөөлөл багатай дэд бүтцийн байгууламжид (Mehta, Baez, and O'Loughton 2002):

- Цаг уур, газарзүй, нутгийн уламжлалт соёлын орчинд тохирсон
- Бүтээн байгуулалтын үед байгальд үзүүлэх нөлөөг хамгийн бага байхад анхаарсан
- Хэлбэр, гоо зүй, тохижилт, өнгөнд анхаарал тавьж орон нутгийн архитектурын өнгө төрхөнд нийцүүлсэн
- Альтернатив технологийн хэрэглээ, усны нөөцөөр хангах тогтвортой арга хэрэгслийг ашиглаж усны хэрэглээг багасгахаар хийгдсэн
- Хатуу хог хаягдал, бохир усыг болгоомжтой зайлуулах механизм
- Эрчим хүчний хэмнэлттэй технологийн шийдлээр цахилгааны хэрэгцээг

хангасан байгууламжийг хэлнэ гэжээ. Цоохор ирвэсний амьдрах орчинд нөлөөлөл багатай дэд бүтэц, байгууламжийн талаар зарим анхаарах зүйлсийг энд дурьдвал:

- 1. Жуулчны бааз:** Тухайн нутагт байгаа байгууламжууд дээр тулгуурлан шийдвэрлэх, аль болох шинээр барихаас зайлсхийх хэрэгтэй. Ялангуяа алслагдмал бүс нутагт тусгайлан зориулсан дэд бүтцийг хөгжүүлэхээс илүүтэй жуулчдыг нутгийн иргэдийн гэрт байрлуулах үр дүнтэй арга байж болох юм. Хэрэв шинэ барилга байгууламж барих бол дотоодод байгаа материалыг ашиглавал зохилтой. Цоохор ирвэсний амьдрах орчинд ихэнхдээ нутгийн малчид уламжлалт гэрт амьдран суудаг. Эдгээрийг жуулчдад зориулсан байр болгон ашиглаж болно (Монгол, Киргизийн зарим аялал жуулчлалын байгууллага аль хэдийн үүнийг хэрэгжүүлж буй).
- 2. Усны менежмент:** Цоохор ирвэсний амьдрах орчин нь хуурай экосистемд байдаг тул усны хомсдол нь эдгээр бүс нутагуудад томоохон асуудал юм. Гэтэл аялал жуулчлалын салбар нь цэвэр усны томоохон хэрэглэгч байдаг. Өндөр уулын хуурай бүсэд ус нэн ховор шинжтэй ч улирлын болон түр зуурын шинж чанартай хэд хэдэн чухал нуур, гол, булаг шанд байдаг. Эдгээр газруудад олон тооны зэрлэг амьтад ашигладаг өвөрмөц ургамлын бүлгэмдэлтэй. Жишээлбэл эдгээр усны нөөцийг олон мянган нүүдлийн усны шувууд (эргийн шувуу, тогоруу гэх мэт) ашигладаг. Аялал жуулчлал нь ариун цэврийн өрөө, шүршүүр, гал тогоо, угаалга зэрэгт усыг их хэмжээгээр ашиглах замаар усны хомсдолд оруулдаг. Аялал жуулчлалын тур операторууд шаардлагатай бол тусгай хамгаалалттай газрын гаднах усны эх үүсвэрээс өөрсдийн хэрэглэх усан хангамж, хадгалах байгууламж зэргийг хариуцах ёстой. Тухайн байгууламж нь эко хуурай бие засах газар, ус бага хэрэглэх шүршүүр байх замаар усны

хамгийн бага хэрэглээг дэмжиж байх хэрэгтэй. Хязгаарлагдмал нөөц бүхий усыг бохирдуулахаас зайлсхийх нь нэн чухал. Нутгийн иргэн өдөрт 10-40 литр ус хэрэглэж байхад жуулчин 84-2000 литр ус зарцуулж байгаа нь маш том ялгаа юм (Gossling 2012, UNESCO 1999). Зарим байгалийн нөөцийн ашиглалтыг 2-р хүснэгтэд харуулав. Үүнд богино угаалгын болон жижиг шүршүүрийн сонголтууд, агааржуулалтын цорго, саарал усыг дахин ашиглах, хуурай жорлонг бордоо болгох, жорлонгын усыг дахин ашиглах, мөн жуулчдад ус ашиглалт түүний хомсдолын талаар чиг хандлага, баримжаа өгөх зэрэг орсон болно.

- 3. Хог хаягдлын менежмент:** Ирвэсний амьдрах орчны ихэнх хэсэгт хог хаягдлын менежментийн систем сайн хөгжөөгүй байдаг. Иймээс нэг удаагийн хуванцарыг ашиглахаас татгалзаж, удаан эдэлгээтэй сав суулгыг ашиглахыг сурталчлах замаар хог хаягдлыг бууруулж болно. Хогоо ялгаж, органик хаягдлыг бордоо болгох хэрэгтэй.
- 4. Эрчим хүч:** Нарны эрчим хүчээр ажиллах зуух, ус халаагч болон биогаз, шаардлагатай бол бага нөлөө бүхий микро гидель зэрэг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглаж болно. Өвлийн улиралд идэвхигүй нарны халаалтыг ашиглах, эрчим хүчинд хэмнэлттэй чийдэнг ашиглах гэх мэт сонголтуудыг зөвлөж байна. Жуулчид эсвэл тур операторууд хонохдоо түлш, түлээгээ өөрсдөө авчрах нь бут сөөгийг зохисгүй ашиглах хэрэгцээг бууруулна. Аялал жуулчлалын зориулалттай газруудаас гадна ил гал асаахыг хориглоно.

Барилга байгууламжийн хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэхэд зориулагдсан хэд хэдэн арга хэрэгслүүд бий, тухайлбал NABERS, Хүрээлэн буй орчны статус (Environmental status), Экопрофайл ба Ногоон Дэлхий (Ecoprofile and Greenglobes) гэх мэт. Эдгээр аргачлалууд нь барилга

байгууламжийг талбайн шинж чанар, нэг хүнд ногдох талбайн хэмжээ, барилгын материалын төрөл, эрчим хүчний хэмнэлт, ялгаруулах утаа, сэргээгдэх болон илүүдэл эрчим хүчний үйлдвэрлэл, усны хэрэглээ, талбай дээрх дахин боловсруулалт, бохир усны цэвэрлэгээ, бохир усыг дахин ашиглах зэрэг үзүүлэлтүүдээр үнэлдэг. Жуулчдад зориулсан байр нь байгаль орчинд ямар нөлөө үзүүлж байгааг баталгаажуулахын тулд хөндлөнгийн үнэлгээг хийлгэж

болно. Хамгийн бага нөлөөлөл бүхий стандартыг дэмжихийн тулд үндэсний эсвэл олон улсын магадлан итгэмжлэгдсэн байгууллагуудтай хамтран ажиллаж болно. Ийм магадлан итгэмжлэлийн тогтолцоог барын амьдрах орчинд хэрэгжүүлдэг байна. Жишээлбэл ToFTigers-ийн PUG Mark итгэмжлэлийн хөтөлбөр. Тухайн газарт баригдаж буй аливаа дэд бүтэц, барилга байгууламжууд нь заавал байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэсэн байх ёстой.

1.5 ХАРИУЦЛАГАТАЙ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ БИЙ БОЛГОХ (ҮНДСЭН ЗАРЧИМ)

Хог хаягдлыг хяналтгүй хаях нь зэрлэг амьтан, хүмүүст аюултай. Манай орны цоохор ирвэсний бүхий ихэнх нутагт хог хаягдлын менежментийн систем сул хөгжсөн байдаг. Айл өрхүүд хуванцар гэх мэт шинэ хог хаягдалыг хэрхэх талаар мэдэхгүйгээгээс уламжлалт аргаар хог хаягдлаа өөрсдөө зохицуулдаг. Зарим айлд ариун цэврийг хангах тухай мэдлэг байдаггүй.

Жуулчид болон тур операторууд өөрсдийн үйл ажиллагаанаас үүссэн хог хаягдлыг тусгай хамгаалалттай газар нутгаас гадна зориулалтын талбайд

цуглуулж, зөөх үүрэгтэй. Дахин ашиглах технологийн хэрэглээг дэмжин хуванцар ашиглахаас татгалзах хэрэгтэй. Хог хаягдлыг хаа сайгүй хаяж байгаа нь усны эх үүсвэрийг бохирдуулахаас гадна хүн, амьтдад шууд аюул учруулж байна.

Хүний хог хаягдлыг хуурай технологи ашиглан зайлуулах нь байгальд ээлтэй арга бөгөөд хүн, мал, амьтанд вирус, нян, шимэгч хорхойн халдвар дамжих эрсдэлтэй тул баазын зориулалтын талбайн гадна ялангуяа усны эх үүсвэрээс хол хог хаягдалын менежментийг авч хэрэгжүүлэх хэрэгтэй.

1.6 ЦООХОР ИРВЭСНИЙ АМЬДРАХ ОРЧИНД АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЗАРЧМЫГ БИЙ БОЛГОХ (МАШ ЧУХАЛ)

Цоохор ирвэсний амьдрах орчинд аялал жуулчлалын зарчмыг бий болгож дагаж мөрдөх нь нэн чухал. Аялал жуулчлалын тур оператор бүр энэ дүрмийг аялал эхлэхээс өмнө болон аялалын туршид бүх үйлчлүүлэгчиддээ мэдэгдэж сахиулах нь зүйтэй. Энэхүү дүрэмд дараах сайн туршлагыг багтаахыг зөвлөж байна. Үүнд:

- Орон нутгийн иргэдтэй хэрхэн харилцах
- Зан заншил, соёлын хэм хэмжээг хэрхэн хүндэтгэх
- Амьтны зан авирт саад болохгүй байх
- Өгөөшийг хориглох

- Бартаат замын хөдөлгөөнд оролцохоос зайлсхийх
- Гэрэл зураг ба видео зураг (шаардлагагүй хурц гэрэл гаргахаас зайлсхийх г.м)
- Хог хаях, ургамал зулгаах, чанга хөгжим дуугаргах гэх мэт үйлдэл хийхгүй байх
- Зэрлэг амьтны амьдрах орчинд хог тарихгүй зориулалтын сав ашиглах гэх мэт

Энэхүү дагаж мөрдөх журамд хууль бус ан, байгалийн нөөцийн зохисгүй ашиглалт, экосистемд үзүүлж буй сөрөг нөлөөний тухай мэдээлэлтэй хэрхэн харьцах

талаар заавар оруулах нь зүйтэй. Мөн хориглосон бүсэд хууль бусаар нэвтрэх гэж мөнгө төлөх болон бусад зөрчлийн тухай тодорхой мэдээллийг багтаасан байх ёстой. Сайн санааны үүднээс хийсэн ч зарим үйлдэл авлигалын нэг хэлбэр болох хор хөнөөлтэй. Энгийн бөгөөд ойлгомжтой зааварчилгаа нь жуулчдыг аюулгүй, тааламжтай аялахад туслана.

1.7 АН АГНУУРЫН ХОРИГИЙГ ХАТУУ ДАГАЖ МӨРДӨХ (ҮНДСЭН ЗАРЧИМ)

Жуулчид бүх төрлийн амьтдыг хүндэтгэж, орон нутгийн дүрэм журмаас гадна агнуурын талаарх үндэсний хууль журмыг чанд сахих хэрэгтэй. ОХУ, Тажикстан, Киргизстан, Казахстан, Пакистан, Монгол зэрэг орнуудад Засгийн газраас гаргасан шийдвэрийн дагуу цоохор ирвэсний амьдрах орчинд түүний идэш тэжээл бологч болон бусад төрлийн ан хийхийг тухайн улсынхаа жилд олгох квотын дагуу, ан агнуур, амьтны тухай зэрэг хуулиудтай зохицуулан зөвшөөрдөг.

Ихэнх тохиолдолд, ан агнуур нь хууль ёсны байсан ч орон нутгийнханы итгэл үнэмшил, соёл зан заншил, тэр ч бүү хэл аялал жуулчлалын үнэт зүйлсийн эсрэг үйлдэл юм. Ийм тохиолдолд ан агнахаас зайлсхийх хэрэгтэй. Сүүлийн хэдэн жилд цоохор ирвэсний амьдрах орчинд ан хийх явдал ихэссэн нь суурин ангийн отог баазуудад хатуу журам тогтоосны улмаас эдгээр баазуудын үйл ажиллагаа суларсантай холбоотой. (Norbdø et al. 2018). Аргаль, Марко-поло хонь, мархор, чоно, баавгай, янгир зэрэг амьтдыг голлон агнаж байна. Ан гөрөө хийх нь маргаантай асуудал бөгөөд ан агнуурын аж ахуй нь байгаль хамгаалал, амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд хэрхэн хувь нэмэр оруулдаг нь тодорхойгүй байна. Зохистой менежменттэй ан агнуурын аж ахуй нь зарим нөхцөлд газрын үнийг өсгөж, агнуурын нөөцөд үнэ цэнэ нэмснээр зэрлэг амьтдыг хууль бус ангаас хамгаалдаг гэж үздэг. Ан гөрөөнөөс олсон орлогын тодорхой хувь шууд орон нутаг хөгжүүлэх сан болон байгаль хамгаалах үйлсэд орох явдал алдаг оног байгаа нь энэхүү үйл ажиллагааг эргэлзээтэй болгож байна.

Хөтөч, байгаль хамгаалагчид ихэнхдээ орон нутгийн талаар маш сайн мэдлэгтэй байдаг бөгөөд байгаль хамгаалах хүнд хэцүү даалгавартай тулгардаг. Жуулчны зүгээс тэдний ажлыг хүндэтгэж, дэмжих нь маш чухал юм. Цоохор ирвэсний амьдрах орчинд аялал жуулчлалыг дэмжих зарчим нь нийтлэг арга барил, үнэт зүйлсийг сурталчлахад тусална.

Нэг талаас менежмент сайтай ангийн үйл ажиллагаа нь хууль бус антай тэмцэх орон нутгийн үнэлэмжийг ихэсгэж зэрлэг амьтны нөөцийг сайжруулах талтай гэж мэтгэлцэх нь бий. Зохион байгуулалттай агнуурын ашгийн тодорхой хувь орон нутгийн сан, нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих нь зөв юм. Ийм ашиг тусыг баримтжуулах шаардлагатай. Агнуурын үйл ажиллагааг муу зохион байгуулснаас болоод энэ бизнесийн нэр хүндэд сөргөөр нөлөөлсөн туршлагауд тэмдэглэгдсэн байдаг. Жишээлбэл, ихэвчлэн том эр бодгалийг түүж агнах нь популяцийн тэнцвэрийг алдагдуулахаас гадна эвэрний хэмжээ буурахад хүргэдэг (Mallon 2013).

Тогтворгүй ан агнуур нь популяцийн огцом бууралтад хүргэж болзошгүй бөгөөд энэ нь ялангуяа ховордсон амьтдыг агнахтай холбоотой. (Singh and Milner-Gulland 2011). Ан гөрөөг зохицуулахын тулд засгийн газар ангийн квотыг тогтоосон байдаг боловч эдгээр нь ихэвчлэн шинжлэх ухааны үндэслэлгүй, санхүүгийн ашиг дээр суурилсан байдаг.

Хэрэв аялал жуулчлал нь ан агнуурын үйл ажиллагаатай холбоотой явагдах бол хуулиар тогтоосон квотыг дагаж мөрдөх шаардлагатай. Эс бөгөөс амьтдын популяцид ноцтой сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Аялал жуулчлалын операторууд нь ангийн аялалыг зохион байгуулахдаа тухайн өгөгдсөн ангийн квот нь тухайн амьтдын тоо толгой буурахад нөлөөлөхгүй гэдгийг судлаачид, мэргэжилтнүүдээс давхар тодруулах нь чухал юм.





ЗАРЧИМ 2

МЭДЭЭЛЭЛ, ХҮНДЭТГЭЛИЙГ ТҮГЭЭХ

Хүрээлэн буй орчин, уламжлалт соёл зан заншлын талаарх мэдээллийг түгээж, цоохор ирвэстэй зэрэгцэн орших нутгийн иргэдийн эрх, итгэл үнэмшлийг хүндэтгэн үйл ажиллагаа явуулсанаар цоохор ирвэсний тогтвортой хамгаалалд хувь нэмэр оруулах юм.

ЗӨВЛӨМЖҮҮД:

2.1 АЯЛАЛЫН ЦАР ХҮРЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭХ (ЧУХАЛ)

Жуулчид, тур операторууд ямар ч үнээр хамаагүй цоохор ирвэс харуулах тал дээр анхаарч, бусад амьтдыг тоохгүй байх тохиолдол гардаг.

Тур операторууд жуулчдад цоохор ирвэсийг харуулна гэсэн амлалт өгөхөөс зайлсхийх хэрэгтэй. Энэ нь жуулчдыг сөргөөр авирлахад хүргэж, тур операторууд амласандаа хүрэх гэж зовдог.

Аялал жуулчлалын маршрутууд зөвхөн цоохор ирвэст анхаарлаа хандуулахаас илүүтэй тухайн газар нутаг, оршин суугчид, соёл, түүхийг багтаасан хөтөлбөрөөр баяжуулан өргөжүүлэхийг санал болгож байна.

Маркетингийн шатнаас буюу жуулчид ирэхээс өмнө тухайн газар нутгийн онцлог, сонирхолтой үзвэрүүдийн мэдээллийг сурталчилгаа, товхимол зэрэгтээ тусгаж өгснөөр жуулчдын хүлээлтийг эхнээс нь зөв үүсгэхэд туслана. *Ирвэсийг харах нь ховор тохиол бөгөөд цоохор ирвэс харуулна гэсэн баталгаа гаргах нь зочдын урмыг хугалахад хүргэж болзошгүй ба энэ цаашлаад өгөөш тавих үйлдэлд хөтлөснөөр цоохор ирвэсэнд аюул учруулж болзошгүй.* Мөн энэ нь бизнесийн хөгжилд муугаар нөлөөлөх аюултай. Үйл ажиллагааныхаа чиглэлийг өргөжүүлэх нь тухайн бус нутгийн бусад гайхалтай боломжуудыг нээх үнэлэмжийг дээшлүүлэх сайн талтай. Цоохор ирвэс нь өвөрмөц экосистем бүхий хүйтэн, хуурай, өндөрлөг орчинд дасан зохицож амьдардаг. Тиймээс жуулчид экосистемийн түвшинд аялахад бэлдэж ирснээр тэдэнд илүү их мэдээлэл, сонирхлыг төрүүлэхээс гадна бусад биологийн олон янз байдал, соёлыг сурталчилах юм.

Энэхүү үйл ажиллагаа нь цоохор ирвэсний мөрөөр аялах, тэдний үлдээсэн шинж тэмдгийг харах зэрэг зүйлд анхаарлаа хандуулан ажиллаж болно. Тэдний мөр, бумбаа, үнэртэн,

ялгадас зэрэг шинж тэмдгүүд нь жилийн туршид байдаг. Аялал жуулчлалын тур операторууд ирвэсний явсан зам, жим бусад шинж тэмдгүүдийг (бумбаа, үнэртэн, ялгадас гэх мэт) тодорхойлоход жуулчдын сонирхолыг татаж болно.

Хүснэгт 2: Аялалын хүрээг тэлэх саналууд

- *Байгалийн түүх, жуулчдын сонирхол татахуйц өвөрмөц онцлогийг нарийвчлан тодорхойлох зорилгоор тухайн бүс нутагт анхны үнэлгээг хийх.*
- *Цоохор ирвэс ба түүний идэш тэжээл болох янгир, аргаль, тарвага, үнэг, шувууны болон ургамлын төрөл зүйлийг бүгдийг нь тодруулж сурталчлах, сурталчилгааны материалыг бэлтгэх. Эдгээр биологийн олон янз төрөл зүйлүүдийн хүйтэн, өндөр бүс нутагт хэрхэн дасан зохицсон шинж чанаруудыг тайлбарлах.*
- *Мөр болон бусад шинж тэмдгийг (бумбаа, үнэртэн, ялгадас гэх мэт) таних ур чадварыг малчдад бий болгох. Ирвэс өвлийн улиралд илүү их ажиглагддаг боловч зуны саруудад мөрдөхөд хэцүү болдог. Гэвч мөр, бумбаа, ялгадас зэргийг аль ч улиралд илрүүлж болно.*
- *Бүс нутгийн биологийн олон янз байдлыг тодорхойлох, зочдын сонирхлыг нэмэгдүүлэхийн тулд автомат камерийг орон нутгийн хуулийн дагуу ашиглах. Нутгийн байгаль хамгаалагч мэргэжилтнүүдийн удирдлаган дор жуулчид автомат камер байршуулахад оролцох, мэдээллийг шинжлэх ухаанд хэрхэн ашигладагыг суралцаж болох юм.*

2.2 УЛАМЖЛАЛТ ЗАН ҮЙЛИЙГ ХҮНДЭТГЭЖ, БЭХЖҮҮЛЭХ (МАШ ЧУХАЛ)

Цоохор ирвэсний хамгаалал нь орон нутгийн иргэдтэй хэрхэн хамтран ажиллахаас хамаарна. Учир нь нутгийн иргэд бол ирвэсний амьдрах орчныг урт хугацаанд хамгаалагчид байдаг. Газар нутгийнхаа талаарх тэдний мэдлэг нь байгаль хамгаалах ажилд асар их үнэтэй.

Байгаль орчинд ээлтэй соёл, уламжлалт зан үйл нь хүрээлэн буй орчныг хамгаалахад чухал хүчин зүйл болж өгдөг. Эдгээрийг аялал жуулчлалын нэг хэсэг болгон тодруулсанаар нутгийн бахархлыг төрүүлж, орон нутгийн иргэд байгаль хамгааллын үйлсэд илүү өргөнөөр оролцоход уриалж болох юм. Нутгийн уугуул иргэдийг хөтчөөр ажиллуулах нь тухайн газар нутаг, соёлын талаарх өвөрмөц мэдлэгийг олж авах боломжийг олгодог төдийгүй тэдний

өрхийн амьжиргаанд нэмэр болдог.

Байгаль орчин, биологийн олон янз байдалд хор хөнөөл учруулж болзошгүй уламжлалт зан үйлийг ойлгох нь чухал боловч эдгээрийг худалдан авалт, сурталчилгаагаар өөгшүүлж болохгүй. Жишээ нь цоохор ирвэсний эд эрхтнийг эмийн эсвэл хоол хүнс) болгон ашиглах гэх мэт. Цоохор ирвэсний идэш тэжээл бологч амьтдын эд эрхтнийг мөн ийм шалтгаанаар болон гар урлал гэх мэт бусад зорилгоор ашиглах тохиолдол байдаг. Эдгээр уламжлалыг санамсаргүй байдлаар хөхүүлэн дэмжих нь хууль бус ангийн олон улсын худалдааны эсрэг хууль зөрчиж байгаа хэрэг. Энэ нь цоохор ирвэсний оршин тогтноход учирч буй томоохон аюул заналын нэг юм.

2.3 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЗОРИЛГООР АМЬТДАД ХҮМҮҮНЛЭГ ЁС ЗҮЙТЭЙ ХАНДАХ (МАШ ЧУХАЛ)

Тэжээвэр амьтдыг аялал жуулчлалын салбарт янз бүрийн шалтгаанаар ашиглах нь элбэг. Морь, илжиг, луус, тэмээ гэх мэт амьтдыг ялангуяа явган аяллын үеэр ачлаганд ашигладаг. Сарлаг, түвд банхар гэх мэт тус нутагт өвөрмөц амьтдыг жуулчидтай хамт гэрэл зураг авахуулахад ашиглах жишээтэй. Тухайн соёл заншилтай холбоотойгоор зэрлэг амьтдыг ч жуулчдад үзүүлэхээр ашигладаг (Жишээ нь Монгол, Киргизэд бүргэдийн ан гэх мэт). Эдгээр нь орон нутгийн орлогын чухал эх үүсвэр болдог. Гэсэн хэдий ч зарим тохиолдолд эдгээр амьтдыг хоол хүнс, усгүйгээр наранд удаан хугацаагаар байлгах, байнгын үзүүлбэрт оруулах, зураг авахын тулд хэвийн бус нөхцөлд байлгах, хэт их ачаалал өгөх, холын зайд алхуулах, зодох гэх мэтээр хүнлэг бус байдлаар харьцаж байна. Ингэснээр амьтдын нөхцөл байдлыг муутгаж, тэднийг маш их стресст оруулдаг. Хэрэв амьтдыг

ашиглаж байгаа бол тэдэнд хүнлэг хандаж, харгислал үзүүлэхгүй байх нь хамгийн чухал юм. Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллагын (2018) мэдээллээр амьтны сайн сайхан байдлыг хангана гэдэгт өвчнөөс урьдчилан сэргийлдэг, мал эмнэлгийн зохих тусламж үзүүлдэг, байр, хоол тэжээлээр хангадаг, аюулгүй орчинд байлгаж хүнлэг харьцахыг хэлнэ гэжээ. Амьтны сайн сайхны төлөө баримтлах үндсэн зарчим нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн 1) өлсөж цангах, хоол тэжээлийн дутагдалаас ангид байх; 2) айдас, стрессгүй байх 3) бие махбодийн болон дулааны тааламжгүй байдлаас ангид байх; 4) өвдөлт, гэмтэл, өвчин эмгэгээс ангид байх; 5) амьтны зан араншингаа илэрхийлэх эрх чөлөөтэй байх гэсэн (Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллага, 2018) таван эрхэд тулгуурладаг байна.



ЗАРЧИМ 3

БАЙГАЛЬ ХАМГААЛАХАД ХУВЬ НЭМРЭЭ
ОРУУЛДАГ БАЙХ

Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг тур операторууд орон нутгийн байгаль хамгаалах санал, санаачилгатай хамтран ажиллаж байгаль хамгаалах үйлсэд шууд ба дам байдлаар хувь нэмрээ оруулдаг байх нь чухал.

ЗӨВЛӨМЖҮҮД

3.1 ОРОН НУТГИЙН БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ (ЧУХАЛ)

Аялал жуулчлалын үйл ажиллагаа ихэвчлэн тусдаа төлөвлөгддөг тул орон нутгийн засаг захиргаа, байгууллагуудыг тойрч гардаг. Энэ нь хамтран ажиллах боломжийг орхигдуулж зарим тохиолдолд үл ойлголцол, зөрчилдөөнд хүргэж болзошгүй.

Аялал жуулчлалын үйл ажиллагаагаа зохион байгуулагчид нь тусгай хамгаалалттай газрын засаг захиргаа, байгаль хамгаалагчид, нутгийн удирдлагууд, ТББ зэрэг орон нутгийн байгууллагуудтай холбогдох нь зүйтэй. Орон нутгийн эрх баригчид хөтөчтэй айлчлалыг төлөвлөн хэрэгжүүлэхэд онцгой анхаарах хэрэгтэй. Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг харгалзан жуулчдын тоо, хэмжээтэй холбоотой албан ёсны хэлэлцээрийг хийн тохиролцох нь зүйтэй (Зарчим 1-ийг үзнэ үү). Энэ талаар хатуу дүрэм байхгүй тул орон нутгийн

удирдлага, иргэдийн төлөөлөгчидтэй хэлэлцэн тохиролцох хэрэгтэй. Жуулчны агентлагууд орон нутгийн удирдлага, байгаль хамгаалах байгууллагуудад зочдын тоо, тэдгээрийн төлөвлөсөн үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангаж хамтран ажиллах нь зүйтэй. Байгаль орчныг хамгаалахад тулгамдаж буй асуудал, жуулчдын байгаль хамгаалах үйлсэд оруулж болох хувь нэмэр зэрэг олон асуудлаар зөвлөлдөж хамтран ажиллах нь чухал юм.

Аялал жуулчлалын агентлагуудад олон байгууллага, засаг захиргаатай хамтран ажиллах цаг зав, нөөц боломж байдаггүй. Ийм тохиолдолд тухайн орон нутагт дагаж мөрдөх дүрэм журмыг багтаасан мэдээ, мэдээллийн сан, зөвлөгөө, дэмжлэгийн эх үүсвэрийг хариуцсан орон нутгийн жуулчны холбоог үүсгэж болно.

3.2 ОРОН НУТГИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ХҮЧИН ЧАРМАЙЛТЫГ ДЭМЖИХ АРГА БАРИЛЫГ БИЙ БОЛГОХ (ЧУХАЛ)

Тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалахад орон нутгийн иргэд, нөхөрлөлийн санаа бодлыг дэмжих хэрэгтэй. Аялал жуулчлалыг ард иргэдийн сайн сайхан байдал, хөгжил, амьтдыг хамгаалахад шууд хувь нэмэр оруулдаг гэж үзэх ёстой.

Орон нутгийн байгаль хамгаалах үйл ажиллагааг шууд дэмжих үүднээс сайтар бодож боловсруулсан арга барилыг дэвшүүлж болно. Хамгийн чухал нь хураамжаас олсон бүх орлогыг орон нутгийн түвшинд байлгахыг бид зөвлөж байна. Арга барил нь нөхцөл байдлын онцлогоос хамааралтай байх боловч дараах зүйлсийг багтааж болно. Үүнд:

а. Санхүүгийн тусламж. Тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх төлбөр нь орлогын чухал эх үүсвэрийг бүрдүүлдэг. Улсын тусгай хамгаалалттай газар нутагт нэвтрэх

төлбөрийн хэмжээг төрөөс тогтоодог боловч төрийн бус байгууллага эсвэл олон нийтийн менежмент бүхий хамгаалалттай газарт төлбөрийн бүтцийг өөрөөр тогтоож болдог. Тогтвортой байдлыг хангахын тулд тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагууд /БОАЖЯ цаг хугацааны явцад төлбөрийн бүтцийг өөрчилж болно. Аялал жуулчлалаас олох ашгийн тодорхой хувийг орон нутгийн байгаль хамгаалах үйл ажиллагааг дэмжихэд зориулж болно.

б. Дэд бүтцийн тусламж. Жуулчны операторууд тухайн орон нутагт илүү тогтвортой дэд бүтцийг бий болгоход дэмжлэг үзүүлэх боломжтой. Жишээлбэл, усны нөөц, хог хаягдлын менежментийн системийг сайжруулах замаар (Зарчим 1-ийг үзнэ үү) хамтарч болох юм. Аялал жуулчлалын

байгууллага нь өөрийнхөө усны хэрэглээг багасгахад анхаарлаа хандуулахаас гадна орон нутгийн усны менежментийг сайжруулахад туслаж болно (ж.нь шаардлагатай бол хиймэл мөсөн гол (<http://icestupa.org/>) барих эсвэл баг, тосгон руу усны суваг барихад туслах гэх мэтээр). Эдгээр алслагдсан нутгуудад ихэнхдээ хог хаягдлын менежментийн зохих системгүй тул аялал жуулчлалын байгууллага нь нэгдсэн хогийн цэг барихад тусалж, хог хаягдлыг ангилан дахин боловсруулахад сурталчилж болно.

- с. Мэдээлэл хуваалцах.** Жуулчны тур операторууд нь орон нутгийн байгаль хамгаалах хөтөлбөрүүдийг чухал мэдээллээр хангах боломжтой. Зэрлэг ан амьтдыг ажигласан тохиолдол, байршлын талаарх мэдээллээс гадна хулгайн ан, хүний үйл ажиллагааны улмаас доройтсон газар нутгийн мэдээлэл нь орон нутгийн байгаль хамгаалагч нарт хэрэгтэй байж болох юм.
- d. Сайн дурын ажил.** Жуулчны операторууд байгаль хамгаалах үйлсэд дэмжлэг үзүүлэх сайн дурын ажилтнуудыг хайж олох, санхүүжүүлэхэд туслах боломжтой.

Жишээлбэл, улирлын чанартай сайн дурын ажилтнууд тодорхой хээрийн судалгаанд шаардлагатай байж болор юм.

Бага хэмжээний хандив, гар цайлгах замаар орлогын эх үүсвэрийг дэмжих боломжууд байж болно. Эдгээр хандивыг хувь хүн эсвэл гэр бүлд өгөхгүй байхыг бид зөвлөж байна. Харин ийм дэмжлэгийг нөхөрлөлийн дундын санг арвижуулах, шийдвэр гаргах үйл явцыг зэрэгт чиглүүлэх ёстой. Энэ нь тодорхой хувь хүмүүсийг дэмжихийн оронд тухайн орон нутагт үзүүлэх үр ашгийг нэмэгдүүлэх болно.

Дээрх саналуудыг Ирвэс Хамгаалах Сан өөрийн түншлэгч байгууллагуудтай зөвлөлдсөний үндсэн дээр цаашид дэлгэрүүлэн боловсруулж болно.

Орон нутгийн байгаль хамгаалах үйл ажиллагаатай хамтардаггүй, дэмждэггүй, ингэснээр байгаль хамгаалах хүчин чармайлтыг алдагдуулж болзошгүй эко аялал жуулчлалын шинэ үйл ажиллагааг зохион байгуулахаас зайлсхийх хэрэгтэй. Нутгийн иргэд болон төрийн бус байгууллагуудтай нягт хамтран ажилласнаар орон нутагт ямар түвшинд хамтран ажиллаж болохыг тодорхойлж болно.

3.3 МОНИТОРИНГ ХИЙХЭД ХУВЬ НЭМЭР ОРУУЛАХ (ЧУХАЛ)

Энэхүү зөвлөмжид тусгагдсан дөрвөн зарчим нь ирвэс болон бусад биологийн олон янз байдалд учрах аюулыг хамгийн бага түвшинд байлгахын зэрэгцээ аялал жуулчлалын ашиг тусыг дээд зэргээр нэмэгдүүлэхэд чиглэгдсэн. Аялал жуулчлалын үр нөлөөг хянах нь нэн чухал боловч байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн талаарх мэдээлэл маш хомс байна. Тиймээс мониторинг нь аялал жуулчлалын нөлөөллийн талаарх бидний ойлголтыг сайжруулж, аюулгүй байдлыг хангах ямар механизмыг хэрэгжүүлвэл зохистойг тодорхойлоход тусалдаг. Аялал жуулчлалын менежерүүд ч мониторинг хийлгүйгээр хариуцлагатай аялал жуулчлалын зорилтуудаа хэрхэн

биелүүлж байгаагаа хамтрагч талууддаа баталгаажуулж, олон нийтэд мэдээлэх боломжгүй юм.

Мониторингийн үйл явцад олон талууд оролцолж болно. Жишээлбэл, зөвлөмжийн хэрэгжилтийг хянах, сайжруулах асуудлыг хариуцсан орон нутгийн хороог байгуулж болно. Эсвэл илүү нарийн мэргэшсэн дотоодын мэргэжлийн мониторингийн ажлыг гүйцэтгүүлж болно. Хяналт шинжилгээний ажлыг санхүүжүүлэх нь байгаль хамгаалах үйлсэд үнэ цэнэтэй дэмжлэг болно.

Аялал жуулчлалын нөлөөллийн гол эрсдэлд хариу үзүүлэх, хариу үйлдлийг хэмжих мэдээллээр хангах олон янзын шалгуур үзүүлэлтүүдийг сонгож болно.

Хамгийн үр дүнтэй үзүүлэлтүүд нь асуудлыг урьдчилан таамаглахад туслах үзүүлэлтүүд болно.

Сэрэмжлүүлэх шалгуур үзүүлэлтүүд нь ноцтой сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, багасгах арга хэмжээг авах боломжийг олгодог. Эдгээрт дараах зүйлийг багтааж болно: тухайн газар усны эрсдэлд орж буй эсэх, хүний нөлөөгөөр талхдал үүсэж буй эсэх (жишээлбэл элэгдэл, хог хаягдал) гэх мэт. Бусад шалгуур үзүүлэлтүүд нь ажил эрхлэлтийн өөрчлөлт, амьтдын харагдац буурах гэх мэт орон нутгийн нийгэм, амьтдад үзүүлж буй урт хугацааны нөлөөллийг хянахад хэрэгтэй байдаг.

Аялал жуулчлалын үйл ажиллагаа дарамт бэрхшээл учруулж буй газар нутаг, нутгийн иргэдэд онцгой анхаарал тавьж ажиллах нь зүйтэй. Жишээлбэл, орон нутгийн оролцогч нар санаа зовж буйгаа илэрхийлсэн эсвэл нөхцөл байдал хурдан өөрчлөгдөж буй газрууд гэх мэт.

Хүснэгт 5: Шалгуур үзүүлэлтийн жишээ

Байгаль орчны үзүүлэлтүүд

- Жуулчдын ашигладаг зам, жим түүний төлөв байдал (элэгдэл, хог хаягдал гэх мэт)
- Газрын доорхи усны хэмжээ ба чанар (давсжилт, бохирдлын түвшин)
- Зэрлэг амьтдын харагдац. Зочдод амьтны төрөл зүйлүүд (цоохор ирвэс, туурайтан болон бусад махчин амьтад)-ийн GPS байршлыг тэмдэглэж авахыг уриалах.

Нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд

- Өрхийн орлогын түвшин
- Орон нутгийн амьжиргааны хэв маяг
- Хотжилт руу шилжиж буй эрчим, хэв маяг





ЗАРЧИМ 4

ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ҮР ӨГӨӨЖ
ХҮРТЭХ БОЛОМЖООР ХАНГАХ

*Санхүүгийн болон бусад ашиг тусыг нутгийн иргэдэд
хүртээх нь чухал.*

ЗӨВЛӨМЖҮҮД:

4.1 ОРОН НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙГ ДЭМЖИХ

(МАШ ЧУХАЛ)

Аялал жуулчлалаас орон нутгийн иргэдэд үзүүлэх ашиг тус нь ихэвчлэн тэнцвэргүй, хуваарилалт муутай байдаг бөгөөд зөвхөн тодорхой бүлэг, хувь хүмүүст л хүрдэг. Ашгийг илүү тэгш байлгах нь тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого, үйл ажиллагааны нэг хэсэг байх ёстой. Иймээс ч аялал жуулчлалын тогтвортой үйл ажиллагаа нь орлогыг олон нийтэд тэгш хүртээхийг шаарддаг. Эс бөгөөс байгаль хамгаалах үйл ажиллагаа болон аялал жуулчлалд удаан хугацааны туршид сөрөг нөлөө үзүүлж, нутгийн иргэдийг хуваагдмал байдалд хүргэж болзошгүй.

Бээжингийн Их Сургуулийн харьяа ШанШуй байгаль хамгаалах төв нь Цинхай мужийн Задуо хошууны Ансай хотод зэрлэг амьтдыг ажиглах аялал жуулчлалын хөтөлбөр боловсруулжээ. Орон нутгийн иргэдээс 22 гэр бүлийг жуулчдад байр, хоол унд, хөтөч, унаагаар хангуулахаар сонгосон. Харин нутгийн засаг захиргаанаас тэдний амьдрах орчныг сайжруулахад хөрөнгө оруулалт хийж тусдаа унтлагын өрөө, угаалгын өрөөтэй болгосон.

Нэг гэр бүлд ногдох дундаж орлого жилд ойролцоогоор 1000 орчим ам доллар бөгөөд үүний 45%-ийг нэг гэр бүл авдаг бол нөгөө 45% нь дундын сан хэлбэрээр орон нутагт очдог. Үлдсэн 10% нь тухайн бүс нутагт ирвэс хамгаалах ажлыг шууд санхүүжүүлэхэд зарцуулдаг. Ангайд гэр бүлд зочлох болон хөтчийн үйлчилгээний үнийг тогтоож, орлогыг тэгш хүртээх үүднээс гэр бүлийг ээлжилж сольдог. Эдгээр тогтолцоонууд нь ашиг тусыг хуваалцаж буй, стандартад нийцэж буйг хянахад чухал юм. Жишээлбэл, зарим гэр бүл гадны оператор компанид байраа зарах эсвэл түрээсэлснээр өөрсдийн үнийг тогтоож, бусадтай хуваалцах үр өгөөжийг хязгаарлаж болох юм. Мөн ерөнхий үйлчилгээний түвшинг хадгалахын тулд инноваци, сайжруулалтыг дэмжиж урамшуулах эсвэл тодорхой хэмжээгээр үнэлэх нь чухал.

Аялал жуулчлалын компаниуд болон жуулчид нутгийн иргэдийг (эмэгтэй, эрэгтэй) үйл ажиллагааныхаа янз бүрийн чиглэлд ажиллуулахыг уриалж байна. Аялал жуулчлал нь нөхөрлөлийн гишүүдэд байнгын болон улирлын чанартай ажил эрхлэх боломжийг олгодог. Жишээ нь орон нутгийн хөтөч, жолооч гэх мэт. Цоохор ирвэстэй бүс нутгийн аялал жуулчлал нь улирлын чанартай бөгөөд аялал жуулчлалын орлогод тэгш бус нөлөө үзүүлж, заримдаа аялал жуулчлалаас олох орлого байхгүй ч үе байхыг үгүйсгэхийн аргагүй юм. Улирлын бус бусад амьжиргааны орлогоо төлөвлөх нь амьжиргааны нэг хэсэг байх ёстой.

Тэднийг урамшуулах байдлаар оролцоо, хүсэл сонирхолыг нь мэдэхийг зөвлөж байна. Эдгээр оролцоо нь нөхөрлөлийн гишүүд болон хувь хүмүүсийн ур чадвар, чадавхийг нэмэгдүүлэх (жишээ нь ноолуур, сүү сүүн бүтээгдэхүүн, зэрлэг амьтдын талаарх мэдлэгийг дээшлүүлэх), бий болгоход чиглэгдэх ёстой. Цаашилбал, шударга цалин хөлс олгох, орлогыг тэгш хуваарилах механизмыг бий болгох нь орон нутгийн түвшинд ардчилсан байдлыг хангахад тусална. Аялал жуулчлалаас олох орлогын тодорхой хэсгийг нөхөрлөлийн дундын санд төвлөрүүлсэнээр энэ салбар тухайн нутагт хөгжих боломжийг нээж, санхүүгийн болон бусад үр өгөөжийг нутгийн бүх иргэдэд адил тэгш хүртээх боломжийг олгоно. Орон нутгийн байгууллагуудын бараа, гар урлалын бүтээлийг жуулчдад зарах боломжоор хангах нь олон нийтэд үр өгөөжийг түгээх сайн арга юм (Zapata et al. 2011). Аялал жуулчлалын байгууллагууд тэдний хамтын ажиллагаа нь эмэгтэйчүүд, цөөнх гэх мэт эмзэг бүлэгт хүндээр тусахгүй байх тал дээр анхаарал хандуулж ажиллах нь чухал.

Нөгөө талаар сайн бодож боловсруулаагүй төсөл, хөтөлбөр нь иргэдийн урмыг хугалах, уламжлалт ур чадвар, мэдлэгийг алдагдуулахаас гадна зөвхөн цөөн хэдэн хүмүүс л ашиг тус

хүртээд өнгөрөхөд хүргэж болзошгүй. Ийм үр дагаварт хянамгай хандаж жилийн

гэрээ сунгах эсвэл өргөжүүлэх үед дахин нягталж эрсдлээс хамгаалах нь зүйтэй.

4.2 ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ (МАШ ЧУХАЛ)

Уламжлалт арга барилыг дэмжихийн зэрэгцээ байгаль хамгаалалтай холбоотой шинэ ур чадварыг орон нутагт бий болгохыг зорих хэрэгтэй. Нутгийн иргэдийг зочлох үйлчилгээ, хоол хийх, тээвэрлэлт, автомат камер байршуулах, компьютер ашиглах, судлаачдын ур чадвар эзэмшүүлэх, өгөгдөлд дүн шинжилгээ хийх, гэрэл зураг авах, хэлний хичээл заах, хөтөч хийх гэх мэт олон чиглэлээр сургаж болно.

Зарим байгаль хамгаалах ТББ-ууд орон нутгийн гар урлалын бүтээгдэхүүний

үйлдвэрлэл, маркетинг сурталчилгааг дэмжих төлөвлөгөө боловсруулдаг (Agvaantseren et al., 2016). Жуулчид ийм бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээний томоохон эх үүсвэрийг бүрдүүлдэг тул гар үйлдвэрлэл, аялал жуулчлал хоорондоо уялдаатай. Жуулчны тур операторууд эдгээр бүтээгдэхүүнийг хот суурин газруудын зах зээлд сурталчлах, орон нутгийн борлуулалтад хувь нэмэр оруулах боломжтой.

4.3 ОРОН НУТГИЙН СОЁЛЫГ ХҮНДЭТГЭЖ, МЭДЛЭГИЙГ БИЙ БОЛГОХ (МАШ ЧУХАЛ)

Цоохор ирвэс бүхий нутагт зэрлэг амьтад, хүмүүс зэрэгцэн оршдог. Хүн байгалийн энэхүү харилцаа нь цаг хугацааны явцад өөрчлөгдөх эерэг ба сөрөг талтай. Энэхүү харилцаа нь аялал жуулчлалд нөлөөлж болох уламжлалт соёл, итгэл үнэмшлээс үүдэлтэй. Аялал жуулчлал нь эерэг харилцааг бэхжүүлэхэд боловсролын бүрэлдэхүүн хэсгийг үйл ажиллагаандаа тусган ТХГН-ийн хүн, байгалийн харилцааг хадгалахын ач холбогдол, орон нутгийн соёл, зан заншил, байгаль орчныг хамгаалах зарчмуудын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх зорилготой байж болно.

Тухайн нутагт амьдарч буй айл өрхийн өв, соёлыг хүндэтгэн хамгаалах ёстой. Орон нутгийн соёл, хүрээлэн буй орчныг хүндэтгэх хэд хэдэн түвшин байдаг.

Тэнд газрын зурагт ороогүй олон тооны ариун дагшин газар байж болно (үүнд шүтээн уулс, гол мөрөн, рашаан ус). Аялал жуулчлалын үйл ажиллагаа нь ариун дагшин газар нутгийг гэмтээхгүй байх (жишээ нь бохирдол, хэт зочлох гэх мэт) нь хамгийн чухал юм. Аялал жуулчлалын бүтэц (байгууламж, зам, зогсоол, үйлчилгээний газар) нь байгалийн онцлог, орон нутгийн соёлын бүтэц/зарчимтай уялдаж байх хэрэгтэй.

Хэрэв тухайн орон нутаг хагас нүүдэлчин бол үүнийг хүндэтгэдэг бүтцийг бий болгох хэрэгтэй. Жишээлбэл, өвөлжөөний бэлчээр нь тодорхой цаг хуучирч, мэдэгдэхгүй болсон ч тэр нь хамгаалах ёстой чухал нөөц хэвээр байна. Орон нутгаас авсан ажилтнууд жилийн турш суурин байдаг ч тэдний аялал жуулчлалд оролцох хүлээлтийг уламжлалт соёлд нь тохируулан өөрчлөх хэрэгтэй.

Гадаад орны хүмүүс уламжлалт зан заншлын тухай ялангуяа хүрээлэн буй орчин - уламжлалт байдлын холбоог мэддэггүй. Байгаль орчны хямралыг (зудтай уур амьсгалын өөрчлөлт гэх мэт) саармагжуулах олон арга барил, зарчмууд байдаг. Дэлхийн хурдацтай хөгжлийн явцад энэхүү уламжлалт мэдлэгээ алдах, зарим зан заншил устгах эрсдэл байсаар байна. Эдгээр ойлголтыг хамгаалах, мэдээлэл авах нь жуулчны үйл ажиллагааны нэг хэсэг байх ёстой. Үүнд гадны хүмүүсийн амьдралын талаарх үзэл бодол нь орон нутгийн мэдлэг, туршлагаас дээгүүр байна гэж үзэхгүй байх нь зохимжтой. Орон нутгийн түүх, зан заншил, нөхцөл байдлын талаар суралцахын тулд олон нийтээс зөвлөгөө авах, хүчин чармайлт гаргах нь жишиг туршлага байх ёстой.



ДҮГНЭЛТ

Дээр дурдсан зарчмуудыг бие биенээс нь эсвэл байгаль орчныг хамгаалах хүчин чармайлтаас тусад нь үзэж, хэрэгжүүлэх нь тохиромжгүй юм. Аялал жуулчлалын салбар нь эдийн засгийн хөгжил, байгаль орчныг хамгаалах, түүний стандартыг бий болгох, хүндэтгэх, ур чадавхийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах замаар эдгээр өндөр уулын бүс нутгийн хөгжилд ашиг тусаа өгнө гэж найдаж байна.

Цоохор ирвэсний амьдрах орчинд аялал жуулчлалыг дэмжих нь энэхүү ховор амьтныг хамгаалах шаардлага бүхий энэ чухал цаг үед өндөр уулын экосистемийг хамгаалах мэдлэг, дэмжлэгийг бий болгох шинэлэг хамгааллын загварыг бий болгож чадна гэж найдаж байна.

Нөгөө талаар дээрх зарчим, зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүйгээс аялал жуулчлал нь боломж гэхээсээ илүү аюул дарамтыг үүсгэж, аялал жуулчлалын салбарын цаашдын хөгжил, тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Хэрэгцээт эх сурвалжууд

- Хүний эрх зөрчигдөхөд аялал жуулчлалын гүйцэтгэхүүргийг судалдаг Их Британид төвтэй байгууллага: <https://www.tourismconcern.org.uk/>
 - Усны хангамжийн тэгш байдал ба аялал жуулчлал: <http://www.ecotourism.org/news/tourism-concern-water-equity-tourism-human-right-global-responsibility>
- Аялал жуулчлалын нөлөөлөл, аялал жуулчлалын тогтвортой байдал сэдвийн хүрээнд зарим эх сурвалжийг дор дурдав.
 - Олон улсын аялал жуулчлалын түншлэл (The International Tourism Partnership) нь тогтвортой аялал жуулчлалын олон шинэ санаа агуулсан вэбсайт: <http://www.greenhotelier.org/>
<http://www.powerhousegrowers.com/green-hotels-innovation-in-sustainable-operations/>
 - Аялал жуулчлал, усны хоорондын уялдаа: <http://www.globalwaterforum.org/2013/07/16/tourism-and-water-interrelationships-and-management/>
 - Энэтхэгийн экотуризм: <http://www.equitabletourism.org/>

АШИГЛАСАН БҮТЭЭЛ

- AGVAANTSEREN, B., ALLEN, P., DASHZEVEG, U., MIJIDDORJ, T. & SNELL RULLMAN, J. (2016) HANDICRAFTS: SNOW LEOPARD ENTERPRISES IN MONGOLIA. IN SNOW LEOPARDS: BIODIVERSITY OF THE WORLD (EDS T. MCCARTHY & D. MALLON), PP. 169–172. ELSEVIER.
- ALEXANDER, J., CUSACK, J.J., PENGJU, C., SHI, K. & RIORDAN, P. (2015) CONSERVATION OF SNOW LEOPARDS: SPILL OVER BENEFITS FOR OTHER CARNIVORES? ORYX, 1.
- CHUNDAWAT, R. S, MERTEN, J. AGASTI, S. SHARMA, K. RAJU U. & MATTHEWS, J. (2017) VALUE OF WILDLIFE TOURISM FOR CONSERVATION AND COMMUNITIES: A STUDY AROUND FOUR TIGER RESERVES IN MADHYA PRADESH (PART-I, TOURISM INFRASTRUCTURE AND REVENUE). BAGH AAP AUR VAN (BAAVAN) AND TOFTIGERS.
- FORREST, J.L., WIKRAMANAYAKE, E., SHRESTHA, R., AREENDRAN, G., GYELTSHEN, K., MAHESHWARI, A., ET AL. (2012) CONSERVATION AND CLIMATE CHANGE: ASSESSING THE VULNERABILITY OF SNOW LEOPARD HABITAT TO TREELINE SHIFT IN THE HIMALAYA. BIOLOGICAL CONSERVATION, 150, 129–135. ELSEVIER LTD.
- GÖSSLING, S., PEETERS, P., HALL, C.M., DUBOIS, G., CERON, J.P., LEHMANN, L., AND SCOTT, D. (2012), TOURISM AND WATER USE: SUPPLY, DEMAND, AND SECURITY. AN INTERNATIONAL REVIEW, TOURISM MANAGEMENT, 33(1), 1-15.
- GUEDES, J.A.D.A., CRABTREE, S.A., BOCINSKY, R.K. AND KOHLER, T.A. (2016). TWENTY-FIRST CENTURY APPROACHES TO ANCIENT PROBLEMS: CLIMATE AND SOCIETY. PROCEEDINGS OF THE NATIONAL ACADEMY OF SCIENCES, 113(51), PP.14483-14491.
- HANDA, O., 1994. TABO MONASTERY AND BUDDHISM IN THE TRANS-HIMALAYA: THOUSAND YEARS OF EXISTENCE OF THE TABO CHOS-KHOR. INDUS PUBLISHING.
- IPCC (2007) CLIMATE CHANGE 2007: THE PHYSICAL SCIENCE BASIS. INTERGOVERNMENTAL PANEL ON CLIMATE CHANGE, 446, 727–728.
- LYNGDOH, S., SHROTRIYA, S., GOYAL, S.P., CLEMENTS, H., HAYWARD, M.W. & HABIB, B. (2014) PREY PREFERENCES OF THE SNOW LEOPARD (PANTHERA UNCIA): REGIONAL DIET SPECIFICITY HOLDS GLOBAL SIGNIFICANCE FOR CONSERVATION. PLOS ONE, 9, E88349. PUBLIC LIBRARY OF SCIENCE.
- MATTHIESSEN, PETER (1978) THE SNOW LEOPARD. VIKING PRESS.
- MALLON, D. (2013) TROPHY HUNTING OF CITES-LISTED SPECIES IN CENTRAL ASIA. SECRETARIAT OF THE CONVENTION ON INTERNATIONAL TRADE IN ENDANGERED SPECIES OF WILD FAUNA AND FLORA (CITES), GENEVA, SWITZERLAND. PP.48
- MURALI, R., REDPATH, S. AND MISHRA, C., 2017. THE VALUE OF ECOSYSTEM SERVICES IN THE HIGH ALTITUDE SPITI VALLEY, INDIAN TRANS-HIMALAYA. ECOSYSTEM SERVICES, 28, PP.115-123.
- NORDBØ, I., TURDUMAMBETOV, B. AND GULCAN, B. (2018) LOCAL OPINIONS ON TROPHY HUNTING IN KYRGYZSTAN. JOURNAL OF SUSTAINABLE TOURISM, 26(1), PP.68-84.
- PU, Z., XU, L. & SALOMONSON, V. V (2007) MODIS/TERRA OBSERVED SEASONAL VARIATIONS OF SNOW COVER OVER THE TIBETAN PLATEAU. GEOPHYSICAL RESEARCH LETTERS, 34. WILEY ONLINE LIBRARY.
- KUMAR, S. AND KUMAR, V. (2014). PERCEPTION OF SOCIO-CULTURE IMPACTS OF TOURISM: A SOCIOLOGICAL REVIEW. INTERNATIONAL RESEARCH JOURNAL OF SOCIAL SCIENCES, 3(2), PP.40-43.
- SINGH, N. J., AND MILNER-GULLAND, E. J. (2011). MONITORING UNGULATES IN CENTRAL ASIA: CURRENT CONSTRAINTS AND FUTURE POTENTIALS. ORYX, 45, 38–49.
- SNOW LEOPARD NETWORK (2014) SNOW LEOPARD SURVIVAL STRATEGY. SEATTLE, WASHINGTON, USA.
- THE INTERNATIONAL ECOTOURISM SOCIETY (1990) THE INTERNATIONAL ECOTOURISM SOCIETY (TIES). FILE:///C:/Users/User/Desktop/IPTPH 2015 4RR.PDF. HTTP://WWW.ECOTOURISM.ORG/.
- UNESCO (1999) WORLD WATER RESOURCES AT THE BEGINNING OF THE 21ST CENTURY.
- WORLD ORGANISATION FOR ANIMAL HEALTH (OIE) (2018). THE TERRESTRIAL ANIMAL HEALTH CODE. 27TH EDITION. ACCESSED: HTTP://WWW.OIE.INT/EN/STANDARD-SETTING/TERRESTRIAL-CODE/ACCESS-ONLINE/



ТОСТ, ТОСОНБУМБЫН БАЙГАЛИЙН НӨӨЦ ГАЗАРТ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ЯВУУЛАХ ЗАРЧИМ, ЗӨВЛӨМЖҮҮД

Энэхүү удирдамж нь Тост, Тосонбумбын байгалийн нөөц газрын (ТТБНГ) зэрлэг амьтад, нутгийн иргэд зэрэгцэн оршин тогтнох боломжийг бүрдүүлсэн аялал жуулчлалын зарчмуудыг нэгтгэн дүгнэсэн баримт бичиг юм. Байгалийн нөөц газар болон түүний эргэн тойронд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх нь онцгой ач холбогдолтой ч нэг талаар зэрлэг амьтдын хамгаалалын боломжийг бүрдүүлж нөгөө талаар эрсдэл бий болгож байгаа юм.

ТОСТ, ТОСОНБУМБЫН БАЙГАЛИЙН НӨӨЦ ГАЗАРТ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРЧМУУД

ТТБНГ нь Монгол орны өмнөд говийн цөл хээр, уулархаг хээр бүхий бэлчээрийн олон төлөв байдлыг хамран оршдог. Тус газар нь соёлын болон экологийн өндөр ач холбогдолтой бөгөөд байгалийн булаг шанд, рашаан ус, уулын оргилууд, гоёмсог байгалийн хавцал, өргөн уудам тал хээр зэрэг олон янзын тогтоц бүхий газруудыг агуулсан байдаг. Уулархаг, цөлөрхөг хээрийн энэхүү хослол нь IUCN-ийн Улаан номонд орсон цоохор ирвэс (*Panthera uncia*), янгир ямаа (*Capra ibex sibirica*), аргаль хонь (*Ovis ammon*) зэрэг олон зүйлийн амьдрах таатай орчин юм. Мөн тус нөөц газраас ховор амьтдын хэд хэдэн зүйл (жишээлбэл, цоохондой мий, евроазийн шилүүс, мануул, шилийн шонхор зэрэг ховор шувууд) тэмдэглэгдсэн байдаг.

ТТБНГ нь хүн амын нягтшил харьцангуй багатай (90 орчим өрхтэй) гол төлөв уламжлалт соёл, зан заншил хадгалсан мал малладаг малчин өрхүүд амьдардаг. Эдгээр хүмүүс ямаа/хонины ноос, ноолуураар өрхийн амьжиргаагаа залгуулдаг бөгөөд үндэсний соёлыг харуулсан олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Эдгээр онцлог нь тус газрыг дотоод, гадаадын жуулчдыг янз бүрийн хэлбэрээр аялал жуулчлал хөгжүүлэх сонирхлыг татахуйц болгож байна.

Цоохор ирвэсний ландшафтад аялал жуулчлалыг дэмжих нь тухайн амьтны тархалтын янз бүрийн бүс бүслүүрт хөгжсөөр байна. 2019 онд буюу “COVID-19” цар тахлаас өмнө Монгол улс аялал жуулчлалын салбараасаа 607 сая орчим ам.долларын орлого олсон бөгөөд мөн онд Монгол улсын ДНБ-д 11.5%-ийг аялал жуулчлалын салбараас бүрдүүлэхээр тооцоолсон байсан байна.

Цоохор ирвэс нь өвөрмөц зүйл амьтан төдийгүй Өмнөговь аймагт дотоод болон гадаадын жуулчдыг татах боломжтой зүйл юм. Аялал жуулчлалын үйл ажиллагаа нь орон нутгийн иргэдэд үнэтэй нөөц

болохоос гадна байгаль хамгаалахад дэмжлэг үзүүлж болох ч нөгөө талаараа аялал жуулчлал явуулснаар зэрлэг амьтад болон тухайн эмзэг байгалийн унаган төрхөд аюул учруулан үр дүнд нь зэрлэг амьтад түүний амьдрах орчныг эрсдэлд оруулах, хог хаягдал хаях, дэд бүтцийн хөгжил зэрэг сөрөг нөлөөлүүд үзүүлж болзошгүй юм.

Зохицуулалтгүй, буруу төлөвлөсөн аялал жуулчлал нь орон нутгийн соёл, эдийн засагт сөргөөр нөлөөлж улмаар нэмэлт бэрхшээл учруулж болох талтай. Монгол Улсын Засгийн газар цоохор ирвэсний амьдрах орчинд экологи, нийгмийн хариуцлагатай арга замаар аялал жуулчлалыг зохион байгуулахын төлөө байгаа юм. 2022 онд Байгаль орчны яамнаас соёл, экологийн хариуцлагатай аялал жуулчлалын үндсэн зарчмуудыг тодорхойлсон баримт бичгийг баталсан (БОАЖЯ, 2022). Энэхүү баримт бичигт аялал жуулчлал нь Монгол орны биологийн олон янз байдлыг хамгаалахад хэрхэн зэрэг нөлөө үзүүлэх болон соёлын өвийг хамгаалах, нийгэмд танигдахуйц үр өгөөжийг авчрах талаар тусгасан байна.

Гурвантэс сумын ЗДТГ, ТТБНГ-ын хамтын менежментийн зөвлөл нь тухайн бүс нутагт хариуцлагатай, тогтвортой аялал жуулчлалыг дэмжих бодлого, чиглэлийг боловсруулж байна. Аялал жуулчлал нь ерөнхийдөө хоёр хэлбэрээр явагддаг бөгөөд жуулчид тур операторуудаар дамжуулан тухайн бүс нутагт очдог эсвэл жуулчид өөрсдөө тухайн бүс нутагт ирдэг. Энэхүү баримт бичиг нь эдгээр хоёр төрлийн аялал жуулчлалд анхаарлаа төвлөрүүлэх ба бусад жуулчид болон сонирхогч талуудад (оршин суугчид болон тэдгээрийн зочид, тусгай хамгаалалттай газар нутгийн ажилтнууд, судлаачид, хэвлэл мэдээллийн хэрэгсэл) зориулсан зарчмуудыг бусад стратегиар тусад нь авч үзнэ.

ХАМТАРСАН ЗАРЧМУУД

Энэхүү баримт бичигт тусгагдсан аялал жуулчлалын зарчмууд нь зэрлэг амьтан, хүмүүсийн эв найртай зэрэгцэн оршихыг дэмжихэд чиглэгдэнэ. Зарчмуудын гол зорилго нь:

1. Зэрлэг амьтдыг хор хөнөөлөөс хамгаалах
2. Уламжлалт соёл, хувийн нууцыг хүндэтгэх
3. Хамгааллын талаарх ойлголтыг дэмжих

Эдгээр зорилгод хүрэхийн тулд тур операторууд доорх 9 зарчмыг

ЗАРЧИМ 1: ЗЭРЛЭГ АМЬТАД, ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ЗОРИЛГООР ЗОЧДЫН ТООГ ХЯЗГААРТАЙ ТОГТООХ

ТТБНГ нь (8965 км²) талбай бүхий уул болон тал хээр зонхилсон нутаг юм. Энэхүү амьдрах орчин нь хүний үйл ажиллагаа, хөгжлийн аюулд өртөж буй эмзэг амьдрах орчныг төлөөлдөг.

Байгалийн нөөц газрын нутаг дэвсгэрт байрлах жуулчны бааз, тээврийн хэрэгслийн тоог зэрлэг амьтад, амьдрах орчныг хамгаалах үүднээс зохицуулах шаардлагатай байна. Амьдрах орчны доройтол, хуваагдлыг багасгахын тулд үүнийг анхааралтай ажиглаж, хянаж, тогтмол дахин үнэлж байх шаардлагатай. Жил бүр жуулчны баазуудад үйлчлэх тээврийн хэрэгслийн

баримтлахыг зөвлөж байна. Эдгээр 9 зарчим дэлхийн цоохор ирвэс түүний экосистемийг хамгаалах хөтөлбөрөөс (GSLEP бодлогын зөвлөмж, 2019) боловсруулсан "Тогтвортой аялал жуулчлалын зарчим, зөвлөмж"-ийн баримт бичиг, Байгаль орчны яамтай хамтран боловсруулсан цоохор ирвэсний амьдрах орчинд хариуцлагатай аялал жуулчлалын зохион байгуулах зарчим, зөвлөмжийг үндэслэж гаргасан (Цоохор ирвэсний амьдрах орчинд аялал жуулчлал явуулах зарчим, зөвлөмжүүд. 2022).

тоо, ор хоногийн хязгаарлалтыг тогтоож **Хамтын Менежментийн Зөвлөлөөр** мөрдүүлэхийг зөвлөж байна.

Аялал жуулчлалын тур операторууд яагаад ийм хязгаарлалт хэрэгтэй байгааг ойлгох, үйлчлүүлэгчид аялал жуулчлалын сөрөг нөлөөллийн талаар ойлголт өгөх замаар энэхүү зарчмыг дэмжин ажиллаж чадна. Эдгээр тур операторууд байгалийн нөөц газар дахь аялал жуулчлалын үндсэн зарчмуудыг (жишээлбэл, тасалбарын механизм, баазын хязгаарлалт, захиалга, машины зохицуулалт гэх мэт) дагаж дэмжин ажиллах ёстой.

ЗАРЧИМ 2: ЗЭРЛЭГ АМЬТДАД СААД БОЛОХГҮЙ БАЙХ

Зэрлэг амьтдад ойртож, гэрэл зураг авах нь ихсэх хандлагатай байна. Үүнийг сайтар бодож, төлөвлөж явуулбал тухайн зэрлэг амьтад бага аюул учруулах юм. Гэсэн хэдий ч жуулчид зэрлэг амьтдад ойртохоор дрон гэх мэт шинэ технологи ашиглах эсвэл өгөөш тавих гэх мэт хүлээн зөвшөөрөгдөөгүй үйлдлүүдээр дамжуулан амьтдыг эрсдэлд оруулж болзошгүй.

Иймээс ажиглагдсан амьтдын зан төлөв, зэрлэг амьтдад саад болон аюул учруулахгүй байхад анхаарлаа хандуулах нь чухал. Дараах зүйлсийг дагаж мөрдөх ёстой.

- Байгалийн нөөц газарт ямар нэгэн ан

хийхийг хориглоно.

- Амьтдад хоол өгөх, өгөөш тавихийг хатуу хориглоно. Зэрлэг амьтдын анхаарлыг татахын тулд үхсэн амьтныг байршуулах, амьд амьтныг уяж өгөөш бэлдэхгүй байх. Махчин амьтад үн төрхийн хувьд хөдөлсөн зүйлийг барьдаг зан төрхтэй байдаг. Амьтанд хоол өгөх, өгөөш тавих нь амьтдын төрөлх зан төрхийг өөрчлөлтөнд оруулж нөлөөлж цаашдаа үр төлдөө энэ мэт адил зүйл хийхийг заана (энэ нь махчин амьтдын дотор асуудал бий болгоно гэсэн үг юм).
- Зэрлэг амьтдад ойртох үед амархан

дайжиж болзошгүй. Зэрлэг амьтдаас зайгаа сайтар нягталж явах бөгөөд тэдэнд саад учруулах эрсдэлээс зайлсхийх хэрэгтэй. Цоохор ирвэс болон бусад зэрлэг амьтдаас бүс бүслүүрээс шалтгаалан 300 - 1000 м- ээс багагүй зайнд ажиглалт хийх хэрэгтэй. Тэдний араас байнга дагаж мөрдөхгүй байх.

- Гүем дагуулсан эм ирвэс амархан хямарч, үүрээ орхин үр төлөө эрсдэлд оруулж болно. Гүемтэй агуй, оромжинд ойртож зураг авахыг хориглоно.
- Зэрлэг амьтдын ашиглаж байгаа уст цэгээс 300 метрээс дотогш ойртохгүй байх. 300 м-ээс дотогш ойртовол зэрлэг амьтад тухайн уст цэгийг ашиглахаас зайлсхийж заримдаа олон хоног ч тухайн цэгт ирэхгүй байх тохиолдол байдаг.
- Махчин шувуудын үүрэнд ойртохгүй, үргээхгүй байх. Аль болохоор үүрнээс холуур тойрч явах, саад болохгүй байх.
- *Амьтныг явган болон техник хэрэгсэлээр хөөж гүйцэх гэж улайрахгүй байх.*
- Амьтны хөдөлгөөнийг хязгаарлах, саад учруулах арга хэрэглэж болохгүй. Үүнд амьтанд саад болох зорилгоор материал шидэх, тээврийн хэрэгслээр замд нь саад учруулах, амьтныг барих, хорих зэрэг орно.
- Хэрвээ зэрлэг амьтад жуулчдад ойртон ирвэл машинаа зөөлхөн зогсоож амьтныг үргээхгүй тайван зураг авч болно. Гэхдээ хэт ойртсон бол тээврийн хэрэгслээсээ буухгүй аюулгүй байдлаа хангах хэрэгтэй.
- Байгальд зэрлэг амьтдын зургийг

авахад дрон ашиглах нь ихсэж байна. Дрон нь амьтдад саад учруулж, тэднийг эрсдэлд оруулах сөрөг нөлөөтэй. Байгалийн нөөц газарт амьтдад саад болох дрон ашиглахыг хатуу хориглоно.

- Жуулчид шөнө хөгжим чангаар тавьж зэрлэг амьтад болон бусад хүмүүстээ саад учруулж болохгүй. Жуулчны баазуудад дуу чимээний түвшинг хязгаарлана.

Бартаа бүхий газарт цоохор ирвэсийг харах нь ховор байдаг. Цоохор ирвэс үзүүлнэ гэсэн баталгаа өгсөн аялал жуулчлалын үйл ажиллагаа нь цоохор ирвэсийг үзэх хүсэлтэй жуулчдыг буруу хандлагад дагуулан хүргэдэг. Учир нь цоохор ирвэс харагдахгүй бол жуулчдын дургүйцлийг төрүүлж, сэтгэл ханамжгүй болгоод зогсохгүй мөнгөө буцаан авах хүсэлт гаргахад хүргэдэг жишээ олон болсон байна.

Аялал жуулчлалын тур операторууд цоохор ирвэс харна гэсэн баталгаа өгөхгүй мөн амлалт өгөхөөс зайлсхийх хэрэгтэй. Харин үүний оронд цоохор ирвэсийн мөрөөр аялах, тэдний үлдээсэн шинж тэмдгийг харах зэрэг зүйлд анхаарлаа төвлөрүүлж болно. Тэдний мөр, бумбаа, самардац, ялгадас зэрэг шинж тэмдгүүд нь жилийн туршид байдаг. Аялал жуулчлалын тур операторууд замнал болон бусад шинж тэмдгүүдийг (бумбаа, үнэртэн, ялгадас гэх мэт) тодорхойлоход зочдын сонирхол, ур чадварыг бий болгож болно. Бид тур операторуудад бусад зэрлэг амьтад, шувуу ажиглалт, тухайн газрын соёлыг багтаасан үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлэхийг зөвлөж байна.

ЗАРЧИМ 3. МОТОРТ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН НӨЛӨӨЛӨЛИЙГ БАГАСГАХ

Жуулчид зөвхөн моторт тээврийн хэрэгслээр (машин, мотоцикл) байгалийн нөөц газрын дотор болон хилээр аялахыг зөвшөөрнө. Гэхдээ тээврийн нөлөөлөл нь зэрлэг амьтад тэдгээрийн амьдрах орчны эрсдэлийн хамгийн том эх үүсвэрүүдийн нэг

болдог тул үүнийг багасгах шаардлагатай. Аялал жуулчлалын тур операторууд стандарт тогтоох нь байгалийн нөөц газарт жолооны дүрмийг дагаж мөрдөхөд чухал үүрэгтэй.

Тост, Тосонбумбын БНГ нь хатуу

хучилттай замгүй, тухайн бүсэд шатахуун түгээх станц байдаггүй. Гэсэн хэдий ч байгалийн нөөц газарт жуулчдын сонирхлыг татдаг гол газруудад нэвтрэх шороон замын сүлжээ бий. Эдгээр замын нөхцөл нь улирлын шинж чанартай байх тул аялал хийхээс өмнө сайтар шалгаж үзэх шаардлагатай. Бүх тээврийн хэрэгсэл үзүүлснээр замын сүлжээнд тодорхойлсон цэгт тээврийн хэрэгсэлээ байрлуулах ёстой. Энэхүү зураг аялал жуулчлалын гол газруудад нэвтрэх боломжийг заахаас гадна нэн эмзэг байгалийн төрх бүхий хөндий, амьдрах орчин, уст цэгүүдээс хол байхаар зураглагдсан. Үүнийг хүндэтгэн үзэх хэрэгтэй.

Байгалийн нөөц газрын бүх хэсэгт замгүй газраар явахыг хориглоно. Ялангуяа зэрлэг амьтадтай ойртохын тулд замаас гарч явж болохгүй. Газрын зураг 1 дээр үзүүлснээр шинэ зам бий болгох эсвэл одоо байгаа замыг өөрчлөхийг зөвшөөрөхгүй. Үүнийг анхааран үзэх нь Тостын нурууны эмзэг экосистем, зэрлэг амьтдын амьдрах орчинд сайнаар

нөлөөлнө.

Дуу чимээ ихтэй UTV, ATV, квад зэргийг байгалийн нөөц газарт судалгаанаас өөр зорилгоор ашиглахыг хориглоно.

Харанхуйд автомашины гэрэл эсвэл нэмэлт гэрлээр амьтдыг гэрэлтүүлэхгүй байх. Энэ нь зэрлэг амьтад, тэдгээрийн байгалийн зан төрхийг (ялангуяа үржлийн үе гэх мэт) алдагдуулах эрсдэлтэй.

Байгалийн нөөц газарт ажиллах зөвшөөрөлтэй, эрх бүхий судлаачид өөрийн тээврийн хэрэгслээр судалгааны ажилд ашиглах зөвшөөрөл авч болно. Энэ нь судалгаа хийх зорилгоор олгосон зөвшөөрөл тул хүндэтгэх шаардлагатай. **Аялал жуулчлалын тур операторууд энэ бүс нутагт судалгаа хийж байгаа машин дагахыг хориглоно.**

Байгалийн нөөц газрын хилийн доторх тээврийн хэрэгслийн тоог 1-р зарчимд нийцүүлэн байгалийн нөөц газрын хамгаалалтын захиргаанаас зохицуулна.

ЗАРЧИМ 4. БАЙГАЛИЙН НӨӨЦ БАЯЛГИЙГ ХЭТ ИХ АШИГЛАХ, СҮЙТГЭХЭЭС ХАМГААЛАХ

Тост, Тосонбумбын БНГ нь ус, ургамал (ургамал, бут сөөг, мод гэх мэт) зэрэг байгалийн нөөцөөр хязгаарлагдмал, эмзэг цөлийн хээр, хээрийн уулын ландшафт юм. Аялал жуулчлал нь байгалийн эдгээр нөөц баялагыг хомсдуулах эх үүсвэр болж, заримдаа бохирдолд хүргэж болзошгүй.

Ус нь говьд маш ховор боловч улирлын болон түр зуурын нуур, усан сан, булаг шанд гарсан байдаг. Эдгээр газрууд өөр өөр ургамлын бүлгэмдэлтэй бөгөөд төрөл бүрийн зэрлэг амьтад ашигладаг. Жишээ нь эдгээр усны эх үүсвэрүүд нь олон мянган нүүдлийн усны шувуудын (эргийн шувуу, тогоруу гэх мэт) дайран өнгөрөх, амьдрах чухал газар болдог.

Аялал жуулчлал нь ариун цэврийн өрөө, шүршүүр, гал тогоо, угаалгын газар, амралт чөлөөт цагаа өнгөрөөх газруудад ус ашиглах замаар усны нөөц бүхий гол устай газруудад дарамт үзүүлдэг. Түүнчлэн түлээнд зориулж бут сөөгийг

зохисгүй ашиглах эрсдэлтэй.

Аялал жуулчлалын тур операторууд аль болох байгалийн нөөц газрын гаднах эх үүсвэрээс усан хангамж, ус хадгалах сав зэргээ өөрсдөө бүрдүүлнэ. Байгалийн нөөц газарт байгаа худгууд нь нутгийн иргэд, тэдний мал сүргийн усаар хангахад чухал ач холбогдолтой бөгөөд аялал жуулчлалын тур операторууд, аялал жуулчлалын бүтээн байгуулалтад ашиглах ёсгүй юм. Аялал жуулчлалын тур операторууд нь жуулчдыг ундны ус, хоол хийх, угаах зэрэгт хэрэглэх усаар хангах үүрэгтэй. Аль болох хуурай бие засах газар, ус бага хэрэглэх шүршүүр бий болгох замаар усны хамгийн бага хэрэглээг дэмжих хэрэгтэй. **Худаг болон ил задгай усыг бохирдуулахгүй байх нь нэн чухал.** Байгалийн нөөц газар нь байгаль орчныг хамгаалах зорилгоор аялал жуулчлалын үйл ажиллагааны нөлөөллийг хянах, цөм

бүс бүхий газруудад (аялалын газар, амьтан ажиглах цэг гэх мэт) байгаль орчныг хамгаалах үүрэгтэй.

Говь цөлийн ургамлууд байгалийн ган гачиг бүхий эрс тэс уур амьсгалд дасан зохицсон бутлаг өвслөг, сөөглөг зонхилдог. Ялангуяа загийг түлээ бэлтгэхэд хэрэглэж байгаа нь түүний нөөцөд аюул учруулж байгаа юм. Заг болон модлог ургамлууд нь газрын элэгдэл, цөлжилтийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд зэрлэг амьтад ч гэсэн загийг хоргодох сүүдрэвч, усны нөөцөө болгон ашигладаг. **Байгалийн нөөц газарт жуулчид ургамал, бут сөөг, мод болон бусад байгалийн баялгийг түүхийг хориглоно.** Аялал жуулчлалын тур операторууд өөрсдийн хэрэглэх түлш, түлээгээ бэлдэж ирэх хэрэгтэй. Аялал жуулчлалын зориулалттай газраас гарч түүний гадна гал түлэхийг хориглоно. Жуулчны баазуудын эрчим хүч, нөөцийн төсөв аль болох хамгийн бага байх ёстой. Халаалт, эрчим хүч гаргаж авах мотор зэрэг эх үүсвэрт найдахаас илүүтэйгээр нарны зайгаар ажилладаг эрчим хүч ашиглах нь байгальд ээлтэй.

Жуулчны баазуудыг тусгай

зориулалтын отоглох цэгүүдэд байрлуулна. Эдгээр баазуудыг байрлуулах газрын зохицуулалтыг байгалийн нөөц газрын хамтын менежментийн зөвлөлтэй ярилцаж шийдвэрлэх бөгөөд зөвхөн тур операторууд болон тэдний жуулчид ашиглана. Байгалийн нөөц газарт зочилж байгаа үүргэвчтэй болон дотоодын аялагчдыг тус газрын дотоод бүсчлэлийн журмын дагуу тогтоосон газарт буулгана. Байгалийн нөөц газрын хамтын менежментийн зөвлөл жуулчны баазуудад зөвшөөрөгдсөн ор, автомашины тооны хязгаарыг тогтооно (1-р зарчим). Эдгээр отоглох цэгт зөвхөн түр зуурын байгууламж (жишээ нь гэр, модон байгууламж, майхан) барихыг зөвшөөрнө. Зориулалтын бүсээс гадуур жуулчны бааз, отоглох цэг байгуулахыг хориглоно.

Хамгийн чухал нь, тур операторууд БНГ - аас гарах үед тухайн газрыг анх байсан байдалд нь үлдээх хэрэгтэйг анхаарах шаардлагатай. Аялал жуулчлалын операторууд баазын талбайд хог хаягдал үлдээхгүй байх хэрэгтэй. Үүний нэгэн адил байгалийн нөөц газарт ирсэн зочид хог хаягдлаа авч явах үүрэгтэй.

ЗАРЧИМ 5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Зохицуулалтгүй хог хаягдал нь зэрлэг амьтад болон хүн төрөлхтөнд ирээдүйд хор хөнөөлтэй. Ихэнхи ТХГН-д хог хаягдлын менежментийн систем маш муу хөгжсөн байдаг. Энэ байгалийн нөөц газарт амьдардаг айл өрхүүд өөрсдөө хог хаягдлаа уламжлалт аргаар зохицуулдаг ч энэ нь шинэ төрлийн хог хаягдал болох хуванцар гэх мэт материалыг зохицуулахад хэтэрхий хэцүү арга юм. Зарим айл өрхүүд ариун цэвэр, эрүүл ахуйн тусгайлсан заалт ч байхгүй байдаг.

Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчид байгалийн нөөц газрын гадна болон тодорхой хэсгүүдэд явуулж буй үйл ажиллагаанаас гарсан хог хаягдлаа цуглуулж хаях нь тэдний үүрэг хариуцлага юм. Хуванцар хэрэглээнээс татгалзаж,

дахин боловсруулсан бүтээгдэхүүний технологийн хэрэглээг дэмжих хэрэгтэй. Эмх замбараагүй хог хаягдал хаяж, ус, булаг шандыг бохирдуулах нь хүн ба зэрлэг амьтад асар их хор хөнөөлтэйг анхаарах хэрэгтэй.

Хүний үйл ажиллагаанаас гарч буй хог хаягдлыг хуурай ариун цэврийн технологи ашиглах нь байгаль орчинд ээлтэй. Баазын орчим болон түүний гадна талд ялангуяа булаг шандын ойр орчимд бие засахаас зайлсхийх хэрэгтэй. Энэ нь зэрлэг амьтад, мал сүрэг болон хүний хооронд тархах вирус тараах эрсдэлтэй.

Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчид энэхүү зарчмыг хянаж, хязгаарлалт тавихад маш чухал үүрэгтэй билээ.

ЗАРЧИМ 6. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ОЛСОН ОРЛОГЫГ ХУВИАРЛАХ

Байгалийн нөөц газар нь орон нутгийн нөхөрлөл, олон нийтийн дэмжлэгийн тусламжтайгаар үйл ажиллагаа явуулдаг. Ялангуяа аялал жуулчлал нь зэрлэг амьтад, орон нутгийн ард иргэдийн амьжиргааг дэмжихэд ихээхэн чухал үүрэгтэй.

Байгалийн нөөц газарт нэвтрэх хураамжийг сумын удирдлагаас тогтоож, эдийн засгийн өсөлттэй холбогдуулан цаг хугацааны явцад өөрчлөгдөх хандлагатай байна.

Байгалийн нөөц газрын хүчин чадлыг харгалзан бид дараах төлбөрийн бүтцийг боловсруулсан ба үүний дагуу өөрчлөлтүүдийг тусгаж байна (Зарчим 1). 2023 онд дараах үнийн тарифыг санал болгож байна:

- Жуулчдын өдрийн тасалбар- дотоодын жуулчидад 5000 төгрөг, гадаадын жуулчдад \$20
- Жуулчдын 5 өдрийн тасалбар- дотоодын жуулчдад 10000 төгрөг, гадаадын жуулчдад \$75
- Машины зөвшөөрөл - Нэг өдрийн

10000 төгрөг

Хамгийн чухал нь нэвтрэх хураамжаас олсон бүх орлогыг орон нутгийн түвшинд зөв хувиарлахыг зөвлөж байна. Үүнд: Байгалийн нөөц газрын захиргаанд (60%), орон нутгийн нөхөрлөлүүдийн холбоонд (40%). Байгалийн нөөц газрын удирдлага энэхүү сангийн үйл ажиллагаа (байгаль хамгаалагч нарын цалин ба эргүүл хяналт) болон хамгаалалтанд (зэрлэг амьтдын хяналт, хамгаалалтын төлөвлөлт) ашиглана. Орон нутгийн нөхөрлөлүүдийн холбоо нь нөхөрлөлүүдийн дундын сангаар дамжуулан зарцуулна.

Аялал жуулчлалын тур операторууд цайны мөнгө, бага хэмжээний хандив өгөх зэргээр дэмжлэг үзүүлэх, орлого олох бусад боломжууд гарч ирэх болно. Эдгээр хандив болон цайны мөнгө зэргийг хувь хүн эсвэл гэр бүлүүдэд бус хамтын шийдвэр гаргах үйл ажиллагааг дэмжихэд, нөхөрлөлийн санд байршуулах хэрэгтэй. Энэ нь тодорхой хүмүүс гэхээс илүү нөхөрлөлд ирэх давуу талыг өргөтгөж байгаа юм.

ЗАРЧИМ 7. ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШГИЙГ ОРОН НУТГИЙН ТҮВШИНД БИЙ БОЛГОХ

Аялал жуулчлалын үр ашиг нь орон нутгийн иргэдэд ихэвчлэн тэнцвэргүй, хуваарилалт муутай очдог ба зөвхөн тодорхой хэсэг бүлэг хүмүүст хүрдэг. Ашгийг илүү тэнцвэртэй байлгах оролдлого нь байгалийн нөөц газрын бодлого болон үйл ажиллагаанаас хамаарч байна.

Аялал жуулчлалын үйл ажиллагаа нь ихэвчлэн орон нутгийн иргэдийн оролцоогүйгээр төлөвлөгддөг ба орон нутгийн бүтэц, байгууллагуудыг оролцуулдаггүй. Энэхүү оролцооны дутагдал, үл ойлголцол, зөрчилдөөнд хүргэж орон нутгийнхний мэдлэг чадвар, дэмжлэгийг дайчлах боломжуудыг алдагдуулж байгаа юм.

Тост, Тосонбумбын байгалийн нөөц газрын орон нутгийн иргэд тухайн газар нутгийг хамгаалах ажилд маш чухал байр

суурийг эзэлдэг. Тостын малчид ба байгаль хамгаалагчид нутгийн байгаль орчны талаар мэдлэг арвин бөгөөд өөрсдөө зэрлэг амьтдын судалгаа, олон нийтийн оролцоо, хамгаалалын хөтөлбөр, тулгарч буй аюулыг бууруулах чиглэлд идэвхитэй оролцдог. Мөн аялал жуулчлалын операторуудад үйл ажиллагаагаа явуулах, төлөвлөхөд хэрэгтэй мэдлэгийг хүргэж болно.

Аялал жуулчлалын компаниуд ба жуулчид үйл ажиллагааны янз бүрийн чиглэлээр орон нутгийн иргэдийг (эмэгтэй, эрэгтэй) ажиллуулахыг зөвлөж байна. Аялал жуулчлал нь орон нутгийн иргэдэд хөтөч, жолооч гэх зэрэг байнгын болон улирлын чанартай ажлын байрны боломжийг олгодог. Цоохор ирвэстэй бүс нутгийн аялал жуулчлал нь улирлын чанартай бөгөөд аялал

жуулчлалаас хүртэх орлого жигд бус, заримдаа найдваргүй гэдгийг мэдэх нь зүйтэй. Жуулчны улирлаас гаднах үеийн амьжиргааны боломжуудыг төлөвлөх нь чухал.

Орон нутгийн иргэдийн оролцоо, үүрэг болон зорилгыг тодорхойлохын тулд тэдэнтэй яриа хэлэлцээ хийхийг дэмжиж ажиллах хэрэгтэй. Эдгээр үүрэг нь орон нутгийн иргэдийн ур чадварыг (жишээлбэл, ноолуурын үйлдвэрлэл, сүүн бүтээгдэхүүний чанар сайжруулах, зэрлэг амьтдын тухай орон нутгийнхны мэдлэгийг дээшлүүлэх) нэмэгдүүлэх, нөхөрлөл болон хувь хүмүүст шинэ ур чадвар, чадавхийг бий болгоход чиглэгдэх ёстой. Зарим өрхүүд аль хэдийн орон нутгийн жижиг

үйлдвэрүүд (орон нутгийн бүтээгдэхүүн борлуулах, таксиний үйлчилгээ, хүнсний үйлдвэрлэл, байр сууц гэх мэт) байгуулсан эсвэл нээхээр төлөвлөж байгаа. Аялал жуулчлалын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд эдгээрийг дэмжиж болох юм.

Орон нутгийн иргэдийн эсвэл байгаль хамгаалагчдын хийж буй хамгаалалын ажилд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Зэрлэг амьтдын (2-р зарчмыг үзнэ үү) болон нөөц газрын дүрэм, журмыг үл хүндэтгэсэн үйл ажиллагаа явуулах нь зохисгүй юм. Тухайлбал, жуулчдыг цоохор ирвэс харуулах зорилгоор өгөөш тавих газар хүргүүлж байгаль хамгаалагчдад мөнгө өгөхийг зөвшөөрөхгүй байх.

ЗАРЧИМ 8. ОРОН НУТГИЙН СОЁЛЫГ ХҮНДЭТГЭЖ, МЭДЛЭГ ОЙЛГОЛТ БИЙ БОЛГОХ

Байгалийн нөөц газарт зэрлэг амьтан болон хүмүүс зэрэгцэн оршин газар нутгаа хуваан амьдардаг билээ. Энэхүү хүн ба байгалийн харилцаа нь цаг хугацааны явцад өөрчлөгдөн эерэг, сөрөг талууд бий болсоор байна. Энэ харилцаа нь аялал жуулчлалд нөлөөлж болох уламжлалт соёл, итгэл үнэмшилтэй холбоотой. Аялал жуулчлал нь эерэг харилцааг бэхжүүлэх зорилттой байх ёстой. Аялал жуулчлалын үйл ажиллагаа нь нутгийн соёл, байгалийн нөөц газар дахь хүн ба байгалийн харилцааг хадгалахын ач холбогдол, байгаль орчныг хамгаалах зарчмуудын талаарх мэдлэгийг дээшлүүлэх гэсэн боловсролын бүрэлдэхүүн хэсэгтэй байж болно.

Тост, Тосонбумбын байгалийн нөөц газарт 90-ээд малчин өрх амьдардаг. Тус нөөц газарт амьдарч буй айл өрхүүдийн хувийн амьдрал, соёлын өвийг зайлшгүй хамгаалах ёстой. Орон нутгийн нөхөрлөл, нутгийн соёл болон амьдрах орчныг хүндэтгэх хэрэгтэй.

Байгалийн нөөц газарт хэд хэдэн онгон дагшин газрууд байдаг бөгөөд тэдгээрийг газрын зурагт оруулаагүй, сурталчилаагүй байж болно (тахилгат уулс, гол мөрөн, булаг шанд). Аялал жуулчлалын үйл ажиллагаа нь онгон дагшин газар

нутгийн ариун нандин чанарыг зөрчихгүй байх, эсвэл санамсаргүйгээр гэмтээхгүй байх (жишээ нь, бохирдуулах, хэт их очиж хүмүүст үзүүлэх гэх мэт) нь хамгийн чухал юм.

Аялал жуулчлалын бүтэц (байгууламж, зам, зогсоол, үйлчилгээний газар) нь байгалийн онцлог, орон нутгийн соёлын бүтэц/дадалтай ихээхэн уялдаж болно. Нутгийн иргэдийн ихэнхи нь хагас нүүдэлчин байдаг тул үүнийг хүндэтгэсэн бүтцийг бий болгох хэрэгтэй. Жишээлбэл, өвөлжөөний бэлчээр нь тодорхой цаг хугацаанд эзэнтэй мэт харагдахгүй ч хамгаалах ёстой чухал нөөц газар хэвээр байна. Орон нутгаас ажилд авсан ажилтнууд жилийн турш суурин ажилтай байх хүсэлтийг тэдний уламжлалд тохируулан өөрчлөх хэрэгтэй.

Гадны хүмүүс уламжлалт зан үйлийг хүрээлэн буй орчинтой холбоотой тухай гүнзгий ойлголт байдаггүй. Байгаль орчны хямралыг (ган, зуд, уур амьсгалын өөрчлөлт гэх мэт) багасгахад туслах олон арга туршлага байдаг. Энэхүү мэдлэгээ алдах, устгах нь хурдацтай хөгжилтэй холбоотой юм. Эдгээрийн тухай мэдээлэл авах, хамгаалах нь жуулчны тур операторуудын үйл ажиллагааны дүрмийн нэг хэсэг байх хэрэгтэй. Үүнд

гадны хүмүүсийн амьдралын талаарх үзэл бодол, давуу байдал нь орон нутгийн мэдлэг, туршлагаас дээгүүр байна гэж үзэхгүй байх зэрэг орно. Орон нутгийн

түүх, зан заншил, нөхцөл байдлын талаар суралцахын тулд ард иргэдээс зөвлөгөө авах, эдгээрийн тухай суралцах хүчин чармайлт гаргах нь чухал.

ЗАРЧИМ 9. ОРОН НУТАГ ДАХЬ ЗЭРЛЭГ АМЬТДЫГ СУДЛАХ БОЛОН ХАМГААЛАХ АСУУДЛЫГ ДЭМЖИХ

Тост, Тосомбумбын байгалийн нөөц газар нь экологийн урт хугацааны судалгааны өвөрмөц газар юм. Ирвэс Хамгаалах Сан байгуулагдсан цагаасаа эхлэн ирвэс, малчин хоорондын асуудалыг бууруулах, олон нийтэд түшиглэсэн байгаль хамгаалах хөтөлбөрөөр дамжуулан цоохор ирвэсийг хамгаалах ажлыг бий болгосон. Цоохор ирвэс болон тэдгээрийн идэш бологч зүйлийг хамгаалахын тулд нутгийн иргэд ба нөлөөллийг дэмжих хэрэгтэй юм. Тус байгууллагын 2008 онд эхлүүлсэн урт хугацааны экологийн судалгаа нь Өмнөговь аймагт төдийгүй Монгол улсад хэрэгжиж байгаа төслүүдээс цоохор ирвэсийг судлах урт хугацааны, өргөн хүрээтэй судалгааны нэг болоод байна.

Байгалийн нөөц газарт хэд хэдэн судалгааны суурин болон суурин бус төвүүд байдаг. Судалгааны багийнхантай урьдчилан тохиролцоогүй бол судалгааны бааз руу очиж болохгүй. Аялал жуулчлалын тур операторууд байгалийн нөөц газрын захиргаатай тохиролцон мөн тэднээр дамжуулан энэхүү явагдаж буй судалгааны давуу, ололттой танилцаж болно. Орон нутгагт явуулж буй судалгааны үр дүн, байгаль хамгаалах ололтын хураангуйг хүсэлт гарган авч болох юм. Цоохор ирвэс, камерын байршлын талаарх зарим нууц мэдээллийг аялал жуулчлалын зорилгоор олгохгүй. Ингэх нь бие даасан амьтдыг хайж олох, тэднийг стресст оруулах эрсдэлийг бий болгож болзошгүй юм. Аялал жуулчлалын тур операторууд эрсдэлийг мэдэх болон түүнийгээ үйлчлүүлэгчидтэйгээ ярилцах замаар судалгааг дэмжих боломжтой.

Аялал жуулчлалын тур операторууд байгалийн нөөц газрын захиргаанд аялалын явцдаа таарсан зэрлэг амьтдын ажиглалтын мэдээлэлийг хуваалцахыг

зөвлөж байна (зураг, видео гэх мэт). Энэ нь аялал жуулчлалын тур операторуудаас судалгааны ажилд оруулах санхүүгийн хувь нэмрээс илүү мэдээлэл болох юм.

Аялал жуулчлалын тур операторууд бусад хөтөлбөрөөс салангид байгаль хамгаалах шинэ санаачилгыг дэмжихээс зайлсхийх хэрэгтэй. Энэ нь тус газарт хийгдэж буй байгаль хамгаалах чухал ажилд сөргөөр нөлөөлж болзошгүй.

ДҮГНЭЛТ

Эдгээр зөвлөмж нь аялал жуулчлалын нөлөөнөөс ард иргэд, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгахаас гадна аль болох эерэг, үр ашгийг нэмэгдүүлэх зорилготойгоор бэлтгэсэн болно. Үүнийг орон нутгийн удирдлагууд, судлаачидтай зөвлөлдсөний үндсэн дээр боловсруулсан. Цоохор ирвэс зэрэг ховордсон амьтдын амьдрах орчинд хүн ба зэрлэг амьтад хоорондоо зэрэгцэн орших явдал улам бүр чухал болж байна. Эдгээр зарчмуудыг Тост, Тосомбумбын байгалийн нөөц газрын нийгэм, байгаль орчны өөрчлөлтөд үндэслэх шаардлагатай. Ийнхүү эдгээр зарчмуудыг 2023 оноос эхлэн 2 жил тутамд хянаж, байгалийн нөөц газрын удирдлага, орон нутгийн оролцогч талууд, Ирвэс хамгаалах сан зэрэг байгаль хамгаалах байгууллагууд хянан үзэх болно. Аялал жуулчлалын тур операторууд туршлага, мэдлэг дээрээ тулгуурлан эдгээр зарчмуудыг цаг хугацааны явцад боловсронгуй болгож, өөрчлөхөд чухал үүрэг гүйцэтгэх юм. Аялал жуулчлалын тур операторууд дээрх зарчмуудыг хүндэтгэж, байгалийн нөөц газар болон орон нутгийн иргэдтэй нягт хамтран ажиллах нь чухал юм.

АШИГЛАСАН БҮТЭЭЛ

GSLEP бодлогын зөвлөмж (2019)
Тогтвортой аялал жуулчлалын зарчим,
зөвлөмж: [https://globalsnowleopard.org/
wp-content/uploads/2020/08/Eco-Tourism-
Principles-web.pdf](https://globalsnowleopard.org/wp-content/uploads/2020/08/Eco-Tourism-Principles-web.pdf)